



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР,
ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

2021

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

Судалгааны захиалагч: Батлан хамгаалах яам

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)
----------------	--

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Эрдэнэбилэг	Хуульч, судлаач
---------------	-----------------

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	
УДИРТГАЛ	5
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	6
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох	
1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	9
2.1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай ойлголт, мөн чанар, хууль зүйн учир холбогдол	9
2.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудын эрх зүйн зохицуулалтын зарим харьцуулалт	15
2.3.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн хууль зүйн учир холбогдол	16
2.4. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуультай холбогдуулан гаргасан Улын дээд шүүхийн тайлбар болон захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд	19
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	21
3.1.“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	21
3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	22
3.3 “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	26
ДӨРӨВ.ДҮГНЭЛТ	29
ТАВ. САНАЛ	31
ЗУРГАА. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	33
ДОЛОО. ХАВСРАЛТУУД	36-46
№ 1 НДСОТТТ хууль, ЦАХТТТ хуулийн зарим зүйл хэсгийн харьцуулалт	36-37
№ 2 ЦАХТТТ хуульд заасны дагуу тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө	38
№ 3 ЦАХТТТ хуульд заасан захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд	39
№ 4 Ахмад настны тухай хуулиас	40-42
№ 5 ЦАХТТТ хуульд заасан ажилласан хугацааг өсгөх зохицуулалтууд	43-44
№ 6 ЦАХТТТ хуулийн үйлчлэлд хамрагдах төрийн тусгай алба хаагчдын ажиллах насны дээд хязгаар	45-46

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГ	Засгийн газар
ЦАХТТТ хууль	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
НДСОТТТ хууль	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хууль
ТАТ хууль	Төрийн албаны тухай хууль
ЦАТ хууль	Цэргийн албаны тухай хууль
ЦАХЭБТ хууль	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль
ЦаАТ хууль	Цагдаагийн албаны тухай хууль
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ТББ	Төрийн бус байгууллага
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн

УДИРТГАЛ

Улс бүр өөрийн улс орныг батлан хамгаалах, улсын онц чухал объектыг хамгаалах, гамшиг осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, зэрэг үүрэг бүхий онцгой дэглэм, хуулийн тусгай зохицуулалттай байгууллага, алба хаагчийг ажиллуулан тэдгээрийн амь нас, эрүүл мэнд, нийгмийн баталгааг хангах шаардлагатай байдаг.

Монгол оронд 1921 оны ардын хувьсгал ялсны дараа “Амь үрэгдсэн партизан цэргийн ар гэрт тэтгэмж олгох тухай” Засгийн газрын тогтоол 1940 он хүртэл “Ардын хувьсгалын ардчилсан шатанд биеэ хүчээр үнэлэгчдийг хамгаалах, цалин хөлс, олгох, өвдөх осолдоход туслах, тэтгэвэр олгох, хөнгөлөлт олгохажлууд хийгдэж байжээ.¹

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 4.1.4-т “Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид ... эрх зүй, нийгмийн хамгааллын баталгааг дээшлүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн Батлан хамгаалах бодлого гэсэн хэсэгт “цэргийн албан хаагчдын эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулах” гэж тус тус тусгагдсаны дагуу 2016 онд цэргийн алба болон хууль сахиулах байгууллагын хууль тогтоомж нэлээдгүй шинэчлэгдэж өөрчлөгдсөн байна.

Энэ ч утгаар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай², Цэргийн албаны тухай³, Монгол Улсын Хилийн тухай хуулиуд 2016 онд, Цагдаагийн албаны тухай, Гамшгаас хамгаалах тухай, Дотоодын цэргийн тухай хуулиуд 2017 онд тус тус шинэчлэгдэн батлагджээ.

Харин Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль⁴ нь 1994 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлагдан 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйлчилснээс хойш энэхүү хуульд 23 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

ЦАХТТТ хуулийн дагуу нийт 18.9 мянган цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгон авч улсын төсвөөс жилдээ 139.4 тэрбум төгрөг зарцуулж байна.⁵

ЦАХТТТ хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Цэргийн албаны тухай хуульд заасан цэргийн алба хаагч, цэргийн албанаас тэтгэвэр, тэтгэмж авагч иргэний хууль ёсны эрх ашиг сонирхолд чиглүүлсэн нь энэхүү хуулийн үйлчлэлд хамрагддаг бусад төрийн тусгай алба хаагчийн хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогоос улбаатай билээ.

Иймд Улсын Их Хурлын “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан ЦАХТТТ хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, судалгааны тайланг боловсруулан⁶ хүргүүлж байна.

¹Чилхаажавын Дагвадорж “Нийгмийн хамгаалал” онол-арга зүй, туршлага, харьцуулалт, 2004, УБ.178 дугаар тал

² 2016.09.01-ний Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай Төрийн мэдээлэл №36, 2016

³ 2016.09.01-ний Цэргийн албаны тухай хууль Төрийн мэдээлэл №36. 2016

⁴ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль Төрийн мэдээлэл №8. 1994

⁵ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль тогтоомж 2020 эмхтгэлийн өмнөх үгэнд 2020 оны байдлаар дурьдсагдсан тоо.

⁶ Судалгааг 2021.05.21-ний өдрөөс 2021.07.21-ний өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль /цаашид “ЦАХТТТ хууль” гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын /цаашид “аргачлал” гэх/ дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн ба “төлөвлөх” шатанд дараах ажил хийгдэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

1995 оноос хэрэгжсэн ЦАХТТТ хуульд 23 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан төдийгүй Цэргийн албаны болон Төрийн албаны хууль тогтоомж шинэчлэгдэх явцад хуулиудын уялдаа холбоо, цэргийн алба хаагчид олгох тэтгэвэр, тэтгэмжийг амьдралд хэрэгжүүлэхэд ойлгомжгүй, өөр хоорондоо зөрчилтэй зохицуулалт үүссэн эсэхийг тодорхойлох зорилгоор хуулийн хэрэгжилтийг үнэлэх зайлшгүй шаардлага тулгарсан гэж үзэн энэхүү судалгааг хийв.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээ тодорхойлох ажиллагаа нь тухайн хуулийн хэрэгжилтэд хамгийн их нөлөөлөл /эерэг болон сөрөг/ үзүүлж буй хэм хэмжээг тусгаарлан сонгох ажиллагаа учраас Төрийн албаны тухай, Цэргийн албаны тухай хуулиуд болон ЦАХТТТ хуулийн уялдаа холбоо, хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох явцад гарч буй тулгамдсан асуудлыг тодорхойлох энэхүү хуулийн дор дурдсан эрх зүйн зохицуулалтуудыг сонгон үнэлгээний хүрээнд хамруулахаар тодорхойллоо. Үүнд:

- 4 дүгээр зүйл /Цэргийн тэтгэвэр, тэтгэмж авах албан хаагч/,
- 18 дугаар зүйл /Нэг удаагийн тэтгэмж авах тохиолдол/,
- 19 дүгээр зүйл /Нэг удаагийн тэтгэмжийн хэмжээ/,
- 20 дугаар зүйл / Нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж/-ийн 1 дэх хэсэг
- Мөн Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дээрх хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. “Зорилгод хүрсэн түвшин”
2. “Практикт нийцэж байгаа байдал”
3. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал”

Хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд ЦАХТТТ хуулийн зорилтод “Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг ... онцгой байдлын асуудал эрхэлсэн ... байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, ... сургуулийн сонсогч нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасныг удирдлага болгон ЦАХТТТ хуулийн 3 дугаар зүйл /Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн төрөл/-ийг Нийгмийн даатгалын тухай хуулийн зүйлтэй харьцуулан онцлогыг тодорхойлон зорилгодоо хүрч байгаа эсэхийг судлан сонгож авлаа.

Мөн хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй алдаа дутагдал, эерэг болон сөрөг байдал, тулгамдсан асуудлыг “Практикт нийцэж байгаа байдал”, “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд ЦАХТТТ хуулийн 1 дүгээр зүйл /Хуулийн зорилт/-ийн 1 дэх хэсэг, 3 дугаар зүйл /Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн төрөл/-ийн зохицуулалтыг сонгосон юм.

Хүснэгт 1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд

д/д	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	1 дүгээр зүйл /Хуулийн зорилт/-ийн 1 дэх хэсэг	Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч /энэ хуульд цаашид "цэргийн алба хаагч" гэх/ нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2	3 дугаар зүйл. Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	1.Цэргийн тэтгэвэр дор дурдсан төрөлтэй байна: 1/ цэргийн жинхэнэ алба болон тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад алба хаасан тэтгэвэр /цаашид "цэргийн алба хаасны тэтгэвэр" гэх/; 2/ хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр; 3/ тэжээгчээ алдсаны тэтгэвэр. 2.Цэргийн тэтгэмж дор дурдсан төрөлтэй байна: 1/ хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж; 2/ нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж; 3/ нэг удаагийн тэтгэмж; 4/ жирэмсний болон амаржсаны тэтгэмж.

Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал”, “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд

д/д	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	6 дугаар зүйл /Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацаа/-ийн 2 дахь хэсэг.	2.Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч өөрөө хүсвэл цэргийн алба хаасан болон даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоож болно.
2.	7 дугаар зүйл /Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тодорхойлох/-ийн 2 дахь хэсэг	2.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тэдний цэргийн алба хаасан сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д, 5 хүртэл жил алба хаасан бол цэргийн алба хаасан нийт хугацаанд авсан цалин хөлсний нийлбэрийг алба хаасан сарын тоонд тус тус хувааж тодорхойлно.

3.	17 ¹ дүгээр зүйл. /Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх/-ийн 3 дахь хэсэг	3.Цэргийн алба хаагч эмэгтэй хууль тогтоомжид заасны дагуу хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаандаа дахин хүүхэд төрүүлсэн бол түүнд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно. Энэ тохиолдолд уг эхийн зөвхөн хоёр удаагийн төрөлт хамаарна
4.	20 дугаар зүйл /Нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж/-ийн 1 дэх хэсэг	1.Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барахад түүний оршуулгад зориулан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж олгоно.
5.	ЦАХТТТ хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	2.“Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч өөрөө хүсвэл цэргийн алба хаасан болон даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоож болно.”

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох

д/д	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1.	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2.	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
3.	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар тогтоон харьцуулна.
4.	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

Судалгааны явцад хууль тогтоомжоос сонгон авсан зохицуулалтын “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэхэд буюу хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулах харьцуулалтын хэлбэрийг ашиглав.

Мөн судалгаанд дурдсан тоо баримт, дэвшүүлсэн санал зэргийг батлах үүднээс тохиолдол судлах аргыг ашиглан бусад улсад хэрхэн хэрэгжиж буй байдлыг авч үзэх нь тохиромжтой байна.

1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Уг үнэлгээний ажилд анхдагч болон хоёрдогч эх сурвалжуудыг хамтатган ашигласан бөгөөд үнэлгээний хүрээнээс хамаарч өөр хоорондоо ялгаатай мэдээллийг ашигласан болно.

Батлан хамгаалах яам, Нийгмийн даатгалын байгууллагаас цэргийн алба хаагчид тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авах эрхтэй холбоотой харилцааг зохицуулсан хуулиуд, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол, шийдвэр, тушаал, журам, дүрэм,

заавар, аргачлал, жишээ, тайлбарыг 2020 оны байдлаар эмхэтгэн гарын авлага гарган хэрэглэгчдийн хүртээл болгожээ.

Судалгааны эх сурвалжаар холбогдох хууль тогтоомж болон цэргийн албаны болон хууль сахиулах байгууллагын тайлан мэдээ, бодлого зохицуулалтын болон санхүүгийн ажилтнууд, цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагч иргэдтэй социологийн ярилцлага түүнчлэн Шүүхийн шийдвэрийн цахим сан болон Нийгмийн даатгалын байгууллагын цахим мэдээллийн санд байршуулсан мэдээлэл, сургалт түүнд хандалт хийсэн иргэдийн сэтгэгдлийг үнэлгээнд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатны гол зорилго нь хэрэгцээтэй, шаардлагатай байгаа ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулан судалснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох юм.

2.1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай ойлголт, мөн чанар, хууль зүйн учир холбогдол

Төрийн албаны хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.1.6 дахь заалтаар “Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн хамаарна” гэж заасан.

Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтаар “цэргийн алба” гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг ойлгоно” гэж тодорхойлжээ.

Цэргийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар цэргийн албыг цэргийн жинхэнэ алба, цэргийн бэлтгэл алба гэж ойлгоно.

ЦАХТТТ хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмжийг цэргийн алба хаагч төрийн албаны онцлог төрөл болох цэргийн албаны хатуу сахилга бат, бусдаас ялгагдах дараах эрхийн хязгаарлалтыг эдэлснийхээ төлөө авдаг. Үүнд:

- ажил үүргээ гүйцэтгэхдээ хууль, дүрэм заасан захирах, захирагдах хэм хэмжээг чанд дагаж мөрддөг, Тухайлбал, байнгын шилжилт хөдөлгөөнд заагдсан газарт үүрэг гүйцэтгэж төв суурин газраас хөдөө орон нутаг ажиллаж амьдрах, захирагч, даргын зөвшөөрөлгүйгээр гадаад улсад зорчих;

- алба хаах орчин, албан хаагчдын эрх зүйн байдлын өвөрмөц онцлог буюу хязгаарлагдмал

- хуулийн дагуу төрийн болон албаны нууцтай харилцаж, албанаас халагдах, чөлөөлөгдсөний дараа тодорхой хугацаанд гадаад улсад байнга оршин суухаар явахгүй байх;

- цэргийн алба хаагч Хөдөлмөрийн хуульд заасан ажил, амралтын цагийг цэргийн дүрэмд заасны дагуу хязгаарлуулдаг

- цэргийн алба хаагчийн алба хааж буй байгаа ангийн байршлаас шалтгаалан түүний оршин суух газрыг тухайн анги, байгууллагын захирагч, дарга тогтоодог

- хүний нөөц сонгох арга хэлбэр дээр онцлог буюу нарийн мэргэжлийн болон цэргийн тусгай дунд, дээд боловсрол шаарддаг

-эх орон, тусгаар тогтнолынхоо төлөө амь биеэ үл хайрлах талаар тангараг өргөж өргөсөн тангарагаа зөрчвөл төрийн хууль ёсны цээрлэл хүлээхдээ иргэдээс хүнд хууль зүйн хариуцлага хүлээдэг

-улс төрийн нам, эвсэл, холбооны гишүүн байх, улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх;

- захирагч, даргын зөвшөөрөлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох, эсхүл цэргийн нэгтгэл, анги, байгууллагад улс төрийн үйл ажиллагаа зохион байгуулахгүй;

ЦАХТТТ хуулиар дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн⁷ эсхүл цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч болон дор дурдсан алба, байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, эрх бүхий алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг улсын төсвөөс санхүүжүүлдэг байна.⁸ Үүнд:

- зэвсэгт хүчний цэргийн жинхэнэ албаны;⁹
- хилийн цэргийн жинхэнэ албаны;¹⁰
- дотоодын цэргийн албаны;¹¹
- цагдаагийн байгууллагын;¹²
- онцгой байдлын байгууллагын;¹³
- шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын;¹⁴
- тагнуулын байгууллагын;¹⁵
- төрийн тусгай хамгаалалтын байгууллагын;¹⁶
- авлигатай тэмцэх газрын;¹⁷
- шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн;¹⁸

ЦАХТТТ хуульд заасны дагуу нийгмийн даатгалын байгууллага нь цэргийн алба хаагчдад цэргийн алба хаасны, хөдөлмөрийн чадвар болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох, олгох ажлыг гүйцэтгэж байна.

2.1.1. ЦАХТТТ хуульд зааснаар цэргийн алба хаагчийн тэтгэвэр дор дурдсан төрөлтэй байна.

- Цэргийн алба хаасны тэтгэвэр;
- Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр;
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуульд заасны дагуу 2020 оны байдлаар 19,1 мянган иргэн ЦАХТТТ хуульд заасны дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр авч байна.¹⁹

⁷ 1998.05.15-ны Дайчилгааны тухай хууль Төрийн мэдээлэл №6. 1998

⁸ Хавсралт № 2 ЦАХТТТ хуульд заасны дагуу тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

⁹ 2016.09.01-ний Зэвсэгт хүчний тухай хууль. ТМ №36

¹⁰ 2016.12.28-ны Монгол Улсын хилийн тухай хууль 2017.02.01-ноос Төрийн мэдээлэл №6, 2017

¹¹ 2017.02.01-ний Дотоодын цэргийн тухай хууль 2017.09.01-нд мөрдөгдсөн. Төрийн мэдээлэл №12, 2017

¹² 2017.02.09-ны Цагдаагийн албаны тухай хууль 2017.03.02-ноос Төрийн мэдээлэл №8. 2017

¹³ 2017.02.02-ны Гамшгаас хамгаалах тухай хууль 2017.02.27-ноос Төрийн мэдээлэл №7, 2017

¹⁴ 2017.06.09-ны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017.07.01-нээс Төрийн мэдээлэл №24.


¹⁵ 1999.07.08-ны Тагнуулын байгууллагын тухай хууль. Төрийн мэдээлэл №35

¹⁶ 1995.04.27-ны Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, 1995.07.01-нээс мөрдөгдсөн. ТМ №7,

¹⁷ 2006.07.06-ны Авлигын эсрэг хууль 2006.11.01-нээс мөрдөгдөн Төрийн мэдээлэл №35. 2006

¹⁸ 2009.07.06-ны Шүүхийн шинжилгээний тухай хууль. Төрийн мэдээлэл №2. 2010

¹⁹ [НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО, төрлөөр \(1212.mn\)](http://1212.mn)



Үзүүлэлт	2018	2019	2020
Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч иргэд олгосон тэтгэврийн хэмжээ	122.9	139.4	153,8

Цэргийн алба хаагчдын тэтгэвэр тогтоолгож байгаа байдал нь Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн дагуу нууцлалтай учраас ЦАХТТ-ийн хуулийн үйлчлэх хэмжээ хязгаарыг нийт байгууллагуудаар бус харин цагдаагийн байгууллын хэмжээнд статистикийг гаргуулан үзүүлэв. Үүнд:

№	Он	Тэтгэврийн төрөл				
		Цэргийн алба хаасны тэтгэвэр	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	
		Алба хаагч	Алба хаагч	Мөнгөн дүн	Алба хаагч	Мөнгөн дүн
1	2017	407	7	41711.5	1	5009.20
2	2018	645	7	43097.7	1	5172.4
3	2019	286	7	53247.9	1	6367.4
4	2020	174	7	52079.5	1	6218.5
5	2021.05	64	7	21199.5	1	2626.6

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тэтгэвэрт гарсан алба хаагчдын сүүлийн 3 жилийн судалгааг авч үзвэл²⁰:

№	Огноо	Тэтгэвэр	
		Бүрэн	% тэнцүүлсэн
1	2019 он	62	15
2	2020	50	14
3	2021 оны 06 дугаар сарын байдлаар	28	10

Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч өөрөө хүсвэл цэргийн алба хаасан болон иргэний байгууллагад ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцуулж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч байна.

Статистикүүдээс дүгнэн үзвэл сүүлийн жилүүдэд ЦАТТТ хуулиар тэтгэвэр тогтоолгож байгаа нь ихсэж байгаа нь хууль тогтоомжийн шинэчлэлийн явцад олон нийтэд 36 сарыг бууруулах, үндсэн цалингийн хэмжээгээр тогтоох улмаар тэтгэврийг ажилласан 7 жилээр тогтоох гэсэн ойлголтуудаас улбаатай байна.

Түүнчлэн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд цэргийн албанд ажилласан хугацааг нэмэгдүүлэн өсгөх эрх зүйн зохицуулалтууд шинэчлэгдсэнтэй холбоотойгоор үндсэн 20, 25 жил ажиллах бус энэхүү асуудлаар захиргааны хэргийн шүүхийн хяналтын шатны шүүхийн тогтоолууд гарснаар өсгөсөн дүнгээр цэргийн алба бүрэн хааснаар тооцож байгаа нь олон алба хаагчид ЦАХТТТ хуульд зааснаар тэтгэвэр тогтоолгож байна.

Тухайлбал, цагдаагийн албанд 18 настай эмэгтэй алба хаагч эргүүлийн цагдаагаар 16 жил ажиллан өсгөн дүнгээр 4 жилийг нэмэн 20 жил ажилласнаар 34 настайдаа, дотоодын цэргийн алба хаагч 18 настайдаа харуулаар 20 жил ажиллан 5 жилийг нэмэн 25 жил ажилласнаар 38 настайдаа цэргийн албаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсч байна.

ЦАХТТТ хуулийн үйлчлэлд хамаарах төрийн тусгай албаны хууль тогтоомж²¹-уудын өсгөн нэмэгдүүлэх эдийн засгийн баталгааг үндсэн 20, 25 жилээ гүйцээсний дараа олгохтой уялдуулсан эрх зүйн зохицуулалтыг хийгээгүйгээс төрийн зарим албад хүний нөөцийн эрсдэлт нөхцөл байдалд бий болгож иржээ. Жишээлбэл, Тулгар төрийн 2230, Их Монгол Улс байгуулагдсаны 815, Ардын хувьсгалын 100, Үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөгөө сэргээн мандуулсны 110 жилийн тохиох 2021 оны 07 дугаар сараас хойш олон төрийн тусгай хаагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгон тухайн байгууллагууд нэг удаагийн тэтгэмж олгох дараалал үүсэхээр байна.

Түүнчлэн УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан "Батлан хамгаалах салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл болон хууль тогтоомжийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар" тавьсан асуулгын хариунд "... дүрмийн бус зөрчил гарсантай холбогдуулан ЗХЖШ-ын даргын 2021 оны 6/360 дугаар тушаалаар ЗХ-ний ... дугаар ангийн захирагч, хурандаа С.Б, ЗХЖШ-ын даргын 2021 оны 6/385... дугаар ангийн ахлагч, тэргүүн ахлагч Б.Н нарыг тус тус албан тушаал болон цэргийн жинхэнэ албанаас нь чөлөөлж, цэргийн тэтгэвэрт гаргасан талаар дурдсан нь сахилгын шийтгэл бус бөгөөд цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох хууль зүйн үндэслэлтэй нийцэхгүй байна.

2.1.2. ЦАХТТТ хуульд зааснаар цэргийн алба хаагчийн тэтгэмж дор дурдсан төрөлтэй байна:

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж;
- Нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж;
- Нэг удаагийн тэтгэмж.

²⁰ ШШГЕГ-ын танилцуулгаас

²¹ Хавсралт №5 аас өсгөн нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтуудыг үзнэ үү.

Зэвсэгт хүчний хэмжээнд 2016-2020 онд цэргийн албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын осол 90 тохиолдол бүртгэгдсэнээс, 48 хүн хөнгөн, 30 хүн хүндэвтэр гэмтэл авч, 12 хүн нас барсан /усанд живсэн-8, РГД-5 гранат тэсэрснээс-2, авто осол-2/ байгаагаас ослын шинжээр чанараар нь авч үзвэл²²:

№	Цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын осол	Хөнгөн	Хүндэвтэр	Амь наснаа алдсан
1	Санамсар болгоомжгүйгээс унах, бүдрэх, халтирах	19	3	
2	Эд зүйлд цохигдох, хавчуулагдах, дарагдах	10	5	
3	Хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөн хийсний улмаас	6	3	
4	Галт зэвсэг, галт хэрэглэл, хортой бодистой буруу харьцах	4	15	2
5	Авто осолд орсон		4	2
6	Усанд живсэн			8
7	Бусад	9		
Дүн		48	30	12
Нийт		90		

2019 онд Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас 8 хүн, 2020 онд 20 хүн бэртэж гэмтэн, хөдөлмөрийн чадвараа түр болон удаан хугацаагаар алдсан байна.

2019 онд Зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэрэг 1, гэмт хэргийн шинжтэй үйлдэл 3 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 1 цэргийн алба хаагч нас барсан бөгөөд тухайн хэргүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шалгуулжээ.

Түүнчлэн, Зэвсэгт хүчний хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдолтой ослоор 2, авто ослоор 2, золгүй байдлаар /амиа хорлосон, өвчний улмаас/ 2 цэргийн алба хаагч, 1 энгийн ажилтан нас барсан байна.

2020 онд Зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэргийн улмаас нас барсан цэргийн алба хаагч байхгүй бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдолтой ослоор 4 /усанд живсэн/, авто ослоор 3, золгүй байдлаар /амиа хорлосон, авто осол, өвчний улмаас/ 6 цэргийн алба хаагч, 1 энгийн ажилтан нас барсан байна.

2021 оны эхний улирлын байдлаар, Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хөдөлмөрийн аюулгүй байдлын осол 2 удаа гарч, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой ослоор нас барсан цэргийн алба хаагч байхгүй.

Түүнчлэн ЦАХТТТ хуулийн тэтгэмжийн үйлчлэлд хамрагддаг цагдаагийн алба хаагчдын статистикийг гаргуулан үзүүлэв. Үүнд:

Тэтгэмжийн төрөл									
№	Он	ХЧТА-ны	Нас барагчийн ар гэрт олгох		Нэг удаагийн				ЖБА
					36 сарын		18 сарын		
		Алба хаагч	Алба хаагч	Мөнгөн дүн	Алба хаагч	Мөнгөн дүн	Алба хаагч	Мөнгөн дүн	Алба хаагч
1	2017	5	15	524337.3	199	5952004.9	8	192,286.0	84
2	2018	7	16	675658.7	214	7853987.6	1	24,884.0	117

²² <http://www.parliament.mn/files/125798> УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан "Батлан хамгаалах салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл болон хууль тогтоомжийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар" тавьсан асуулгын хариу

3	2019	11	8	377525.1	584	22363204.1	3	79,685.0	109
4	2020	8	8	383547.3	482	19184432.9	5	167,300.8	102
5	2021.05	3	5	260617.7	68	3011030.1			39

ЦАХТТТ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт дараах тохиолдолд амь насаа алдсан цэргийн алба хаагчийн сарын цалин хөлсний дунджаар, хэрэв байлдагч, түрүүч, цэргийн үүрэгтэн амь насаа алдсан бол ахлагчийн сарын цалин хөлсний дунджаар тооцож ар гэрт нэг удаа олгоно. Үүнд:

- Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн байлдааны талбар, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, байлдааны галт хэрэгслээр буудлага хийх, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай хорт бодистой үүргийнхээ дагуу харьцах, гамшиг, онцгой нөхцөлийн байдалд ажиллах, улсын хил, онц чухал объектыг хамгаалах үед амь насаа алдвал 10 жилийн,
- дээрх тохиолдлоос бусад албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас ослын улмаас амь насаа алдвал 5 жилийн,
- албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй осол, тарилгын дараах хүндрэл, ердийн өвчний улмаас амь насаа алдвал 3 жилийн,

Сүүлийн жилүүдэд цэргийн нэгтгэл, ангийн байрлалд, цэргийн алба хаагчдын дунд гарч байгаа гэмт хэрэг, зөрчил болон хууль, дүрмийн бус харьцаа, үйл ажиллагааны улмаас хүний амь нас эрсдэх, эрүүл мэндээр хохирох асуудал буураагүй байна.

Энэхүү хуулийн зохицуулалтын дагуу ослоор нас барсан цэргийн алба хаагчдын ар гэрт нь ЗХЖШ-ын даргын тушаал²³-аар нэг удаагийн тэтгэмж олгож ирсэнийг сүүлийн 4 жилийн байдлаар харуулбал:

№	Цэргийн алба хаагч	Тэтгэмж /төгрөг/	Төрөл	Шалтгаан
2017 он				
1	ЗХ-ний ... дугаар ангийн офицер Б.М-ийн ар гэрт	99,218,160	Нэг удаагийн тэтгэмж	осол
2	ЗХ-ний ... дугаар ангийн ахлагч Б.А-гийн ар гэрт	65,713,440	Нэг удаагийн тэтгэмж	осол
2018 он				
3	ЗХ-ний дугаар ангийн ахлах ахлагч С.М-ын ар гэрт	41,701,078	Нэг удаагийн тэтгэмж	живсэн
4	ЗХ-ний ... дугаар ангийн ахлагч сургагч ахлагч Ч.Э-гийн ар гэрт	28,219,968	Нэг удаагийн тэтгэмж	зуурдаар нас барсан
2019 он				
5	ЗХ-ний ... дугаар ангийн байлдагч Б.А-гийн ар гэрт	30,152,760	Нэг удаагийн тэтгэмж	Сургалтын төвд нас барсан
		1,000,000	Оршуулгын зардал	
6	ЗХ-ний ... дугаар ангийн ахлах ахлагч Я.Г-ын ар гэрт	48,358,843	Нэг удаагийн тэтгэмж	автомашины ослоор нас барсан
		1,000,000	Оршуулгын зардал	
7	ЗХ-ний ... дугаар ангийн байлдагч Б.Н-ын ар гэрт	30,152,760	Нэг удаагийн тэтгэмж	автомашины ослоор

²³ <http://www.parliament.mn/files/125798> УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан "Батлан хамгаалах салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл болон хууль тогтоомжийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар" тавьсан асуулгын хариу

		1,000,000	Оршуулгын зардал	нас барсан
8	ЗХ-ний ... дугаар ангийн энгийн Х.Т-гийн ар гэрт	1,000,000	Оршуулгын зардал	өвчнөөр нас барсан
9	Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн ахлах ахлагч П.Тэгшжаргалын ар гэрт	1,000,000	Оршуулгын зардал	амиа хорлосон
10	ЗХ-ний ... дүгээр ангийн офицер Г.Т-ын ар гэрт	62,834,337	Нэг удаагийн тэтгэмж	автомашин осол
2020 он				
11	ЗХ-ний ... дүгээр ангийн цэргийн гэрээт албаны байлдагч С.А-ны ар гэрт	39,838,680	Нэг удаагийн тэтгэмж	живсэн
12	ЗХ-ний ... дугаар ангийн ахлагч Г.Г-ын ар гэрт	22,576,392	Нэг удаагийн тэтгэмж	живсэн
13	ЗХ-ний ... дугаар ангийн дэд ахлагч Ж.А-ийн ар гэрт	23,711,472	Нэг удаагийн тэтгэмж	живсэн
14	ЗХ-ний ... дугаар ангийн дэд ахлагч Б.Б-гийн ар гэрт	25,175,556	Нэг удаагийн тэтгэмж	живсэн
Нийт		552,653,446		

2.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай болон ЦАХТТТ хуулиудын зарим эрх зүйн зохицуулалтын харьцуулалт²⁴

2.2.1. Тэтгэврийн төрлийн талаар:

№	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хууль	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
1	2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн төрөл 1.Тэтгэврийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэвэр дор дурдсан төрөлтэй байна: 1/ өндөр насны тэтгэвэр; 2/ тахир дутуугийн тэтгэвэр'; 3/ тэжээгчээ алдсаны тэтгэвэр.	3 дугаар зүйл. Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн төрөл 1.Цэргийн тэтгэвэр дор дурдсан төрөлтэй байна: 1/ /цаашид "цэргийн алба хаасны тэтгэвэр" гэх/; 2/ хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр; 3/ тэжээгчээ алдсаны тэтгэвэр.

Тэтгэврийн даатгалын сангаас даатгуулагчид НДСОТТТ хуульд заасны дагуу хуульд заасан болзлыг ханган нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн тохиолдолд өндөр насны тэтгэврийг авах бол цэргийн алба хаагчид ЦАХТТТ хуульд заасан шалгуурыг хангавал төрөөс нийгмийн даатгалын шимтгэлийг төлж цэргийн алба хаагчийн тэтгэврийг тогтоолгоно.

2.2.2. Тэтгэмжийн төрлийн талаар:

№	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хууль	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
---	---	--

²⁴ хавсралт № 1 НДСОТТТ хууль, ЦАХТТТ хуулийн зарим зүйл хэсгийн харьцуулалтыг үзнэ үү.

1	2.Тэтгэмжийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэмж дор дурдсан төрөлтэй байна: 1/хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж; 2/жирэмсний болон амаржсаны тэтгэмж; 3/ оршуулгын тэтгэмж.	2.Цэргийн тэтгэмж дор дурдсан төрөлтэй байна: 1/ хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж; 2/ нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж; 3/ нэг удаагийн тэтгэмж; 4/ жирэмсний болон амаржсаны тэтгэмж.
---	--	---

Цэргийн алба хаагч цэргийн алба хаасны онцлогоос шалтгаалан нэг удаагийн тэтгэмж тус тус авах онцлогоор НДСОТТТ хуулийн зохицуулалтаас ялгагдаж байх бөгөөд төрийн алба хаагчдын хувьд Төрийн албаны хуульд заасан 36 сар хүртэл буцалтгүй тусламжийг ЗГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын зохицуулалддаг байна.

Түүнчлэн цэргийн алба хаахдаа эх орон, тусгаар тогтнолынхоо төлөө амь биеэ үл хайрлах тангарагтаа үнэнч байж амь насаа алдсан тохиолдолд нас барагчийн ар гэрт тэтгэмж олгох онцлогтой байна.

2.2.3. Ажилласан жил болон насаар тэтгэвэр тогтоолгох талаар²⁵:

ЦАХТТТ хуулиар нас харгалзахгүйгээр 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй, 20-оос доошгүй жил алба хаасан эмэгтэй, байлдааны нисдэг тэрэгний нисгэгчээр 23-аас доошгүй жил цэргийн алба хаасан, байлдааны тийрэлтэт сөнөөгч онгоцны жинхэнэ нисгэгчээр 20-оос доошгүй жил цэргийн алба хаасан бол цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй байна.

Мөн дээрх хугацааг хангаагүй боловч 10-аас доошгүй жил цэргийн алба хаасан цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлтөөр, эсхүл биеийн эрүүл мэндээр эсхүл цэргийн алба хаах нас хэтэрч чөлөөлөгдсөн бол цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах авах эрхтэй боловч Цэргийн албаны тухай хуульд заасны насны дээд хязгаарт хүрсэн тохиолдолд энэхүү тэтгэврийг авах эрх үүсдэг байна.

Харин ЦАХТТТ тухай хуулийн үйлчлэлд хамаарч байгаа цэрэг, цагдаагийн алба хаагч зэрэг холбогдох хуульд насны дээд хязгаарыг тогтоосон алба хаагчаас бусад төрийн алба хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан насны хязгаарыг мөрдөнө.

2.2.4. Цэргийн алба хаагчийн тэтгэврийн хэмжээний талаархи харьцуулалт:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хууль	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
5 дугаар зүйл. Өндөр насны тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл 1.Өндөр насны тэтгэврийг даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого /цаашид "хөдөлмөрийн хөлс" гэх/-ын 45 хувиар тогтооно.	9 дүгээр зүйл. Цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл 1.Цэргийн алба хаасны тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно.

Цэргийн алба хаасны тэтгэврийг сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтоох бол НДСОТТТ хуульд даатгуулагчийнх 45 хувиар тогтоогддог онцлогтой байна.

2.3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хууль зүйн учир холбогдол

²⁵ Хавсралт № 6 ЦАХТТТ хуулийн үйлчлэлд хамрагдах төрийн тусгай алба хаагчдын ажиллах насны дээд хязгаарын харьцуулалтыг үзнэ үү.

ЦАХТТТ хууль нь 1994 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлагдан 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйлчилснээс хойш энэхүү хуульд 23 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсныг тоймлон үзье. Үүнд:

№	огноо	Агуулга
1	2020.05.14	Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор “Төрийн тусгай хамгаалалт”-ыг хуулийн үйлчлэлд хамруулсан
2	2018.10.19	7 жилийн цалин хөлсний нийлбэрийг 84-т” гэснийг “5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д” гэж, “7 хүртэл жил” гэснийг “5 хүртэл жил” буцаалт
3	2018.06.27	Дайчилгааны тухай хууль хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор “дайчилгааны” гэснийг “дайчилгаатай” гэж өөрчилжээ.
4	2018.02.02	“дараалсан 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д” гэснийг “дараалсан 7 жилийн цалин хөлсний нийлбэрийг 84-т” гэж, “5 хүртэл жил” гэснийг “7 хүртэл жил” гэж тус тус өөрчилжээ.
5	2017.02 .09	Дотоодын цэргийн тухай батлагдсантай холбогдуулан “дотоодын цэргийн албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч,” хуулийн үйлчлэлд хамруулсан.
6	2017.01. 26	Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан болзол хангасан цэргийн алба хаагчийн иргэний байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан нэг жилийг зургаан сараар бодон цэргийн байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцож ... тэтгэвэр тогтоож болно.” Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанаас илүү алба хаасан жил тутамд 1.5, сар тутамд 0.125 хувиар цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон цалин хөлснөөс тооцож нэмэгдэл олгоно.” “2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаагаар цэргийн алба хаасан иргэн өндөр насны болон тахир дутуугийн тэтгэвэр, эсхүл тухайн иргэн нас барсан бол түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргасан тохиолдолд уг хугацаанд төлөгдсөн байвал зохих шимтгэлтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу нийгмийн даатгалын санд шилжүүлэн төлнө.”
7	2016.09.01	Цэргийн албаны хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж тус тус өөрчилсүгэй.
8	2015.12.04	Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болохтой холбогдуулан энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. гэж тодотгосон байна.
9	2014.01.24	Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохтой холбогдуулан “Авлигатай тэмцэх газар”-ын эрх бүхий алба хаагчид хуулийн үйлчлэлд хамрагджээ.
10	2014.01.16	Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсантай холбогдуулан дотоодын цэрэг”-ийг хуулийн үйлчлэлээс хасжээ.
11	2011.12.09	ЦАХТТТ хуульд заасан “комиссар” гэснийг хасжээ.

12	2010.07.02	Энэхүү нэмэлтээр цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн олон нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал, Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч өөрөө хүсвэл цэргийн алба хаасан болон даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоож болох, цэргийн алба хаасан нэг жилийг 1 жил 6 сар иргэний байгууллагад ажиллан шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцох, иргэний байгууллагад ажилласан нэг жилийг 6 сар цэргийн байгууллагад ажиллан шимтгэл төлсөн хугацаанд оруулах, 36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгох эсхүл энэхүү тэтгэмжийн 18 сар хүртэлх хугацаанд ногдох хэсгийг урьдчилан авах гэх мэт.
13	2010.05.20	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болохтой холбогдуулан “энхийг сахиулах” гэснийг “энхийг дэмжих” гэж өөрчилжээ.
14	2009.12.03	Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчин төгөлдөр болохтой холбогдуулан “цагдаа,” гэсний дараа “шүүхийн шинжилгээний,” гэж тус нэмжээ.
15	2008.05.08	ЦАХТТТ хуулийн “17 ¹ дугаар зүйл /Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх/, 17 ² дугаар зүйл /Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хэмжээ, хугацаа/-д өнөөгийн нэмэлтийг хийжээ. Мөн ЦАХТТТ хуулийн 7 дугаар зүйл /Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тодорхойлох/-ийг өөрчлөн найруулжээ.
16	2005.05.26	"гамшгаас хамгаалах","галын" гэснийг “онцгой байдлын асуудал эрхэлсэн” гэж өөрчилжээ.
17	2004.04.23	Терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болохтой холбогдуулан "энхийг сахиулах үүрэг гүйцэтгэх, " гэсний дараа "террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох," гэж нэмжээ.
18	2003.06.20	Гамшгаас хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болохтой холбогдуулан "галын" гэснийг "гамшгаас хамгаалах" гэж; "Гал түймэртэй тэмцэх" гэснийг "Гамшгаас хамгаалах" гэж тус тус өөрчилжээ.
19	2003.06.12	Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон боловч 12 сараас доошгүй хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан тохиолдолд тэтгэврийн хэмжээг анхны тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас бодож энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хувиар өөрчлөн тогтооно гэж нэмжээ.
20	2003.01.20	ЦАХТТТ хуулийн 5 дугаар зүйлийн "төвлөрсөн" гэснийг хасжээ.
21	2000.04.20	Дархлаажуулалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс "осол " гэсний дараа "тарилгын дараах хүндрэл " гэж нэмжээ.
22	1999.06.10	Энэхүү нэмэлтээр "цагдаа" гэсний дараа ", “галын” гэж өмнөх нэмэлтийн хууль зүйн техникийг боловсронгуй болгожээ.

23	1999.05.28	Галын аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс энэ хуульд гал түймэртэй тэмцэх байгууллагын алба хаагч."-ийг хуулийн үйлчлэлд хамруулжээ.
----	------------	---

Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дүгнэн үзвэл:

- ЦАХТТТ хуулийн үйлчлэлтэй холбоотой 6 удаагийн нэмэлт, Тухайлбал, Онцгой байдал, Авлигатай тэмцэх, Төрийн тусгай хамгаалалт, Дотоодын цэрэг, Шүүхийн шинжилгээний байгууллагыг хуулийн үйлчлэлд хамруулсан байна.
- хуулийн шинэчлэл, өөрчлөлттэй холбоотой хууль зүйн техникийн 7, Тухайлбал, "Гал түймэртэй тэмцэх" гэснийг "Гамшгаас хамгаалах", "гамшгаас хамгаалах", "галын" гэснийг "онцгой байдлын асуудал эрхэлсэн", "энхийг сахиулах" гэснийг "энхийг дэмжих", "цэргийн албан" гэснийг "цэргийн алба гэж өөрчилжээ.
- агуулгын зарчмын шинжтэй 10 удаагийн нэмэлт өөрчлөлт орсноос 2003 оны 06 дугаар сарын 12, 2008 оны 05 дугаар сарын 08, 2010 оны 07 дугаар сарын 02, 2017 оны 01 дүгээр сарын 26-ны нэмэлт өөрчлөлтүүд нь зарчмын шинжтэй цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалсан эрх зүйн зохицуулалтууд байна.

Энэ нь Монгол Улсын Их Хурлаас улс орны нийгэм, эдийн засгийн байдалтай уялдуулж, гадаадын бусад улсын цэрэг, цагдаа болон төрийн тусгай үүрэг гүйцэтгэгч байгууллагын албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжтэй ойртуулж, нийгмийн хамгааллыг сайжруулах зорилтын хүрээнд ЦАХТТТ хууль 2010 онд зарчмын шинжтэй хэд хэдэн өөрчлөлт оруулсны нэг нь хуулийн үйлчлэлд хамаарал бүхий албан хаагч урд нь иргэний байгууллагад ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нэг жилийн хугацааг 6 сар цэргийн байгууллагад ажилласнаар тооцож тэтгэврийг нь нэмэгдүүлэн тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байна.

2.4. ЦАХТТТ хуультай холбогдуулан гаргасан Улын дээд шүүхийн тайлбар болон захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд

2.4.1. Улсын дээд шүүхийн тайлбарын талаар

Монгол Улсын Дээд шүүхийн 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн "Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" 32 дугаар тогтоол нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд ЦАХТТТ хуулийн Дээд шүүхийн тайлбар цэст байгаа билээ.

2016 онд Цэргийн албаны тухай болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаар 1992 оны Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүйд тооцогдсон билээ.

Улсын дээд шүүхийн 32 дугаар тогтоолын тогтоолын 1. 2 дахь хэсэг нь Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсноор хүчин төгөлдөр байх шинж үгүйсгэгдэж харин 3 дахь "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-д заасан "цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй" гэдгийг тухайн албыг хаах насны дээд хязгаарт хүрснээс бусад тохиолдолд цэргийн албан хаагч өөрийн санаачилгаар тэтгэвэр тогтоолгох боломжтой гэж ойлгоно." хэсэг хүчинтэй гэж дүгнэгдэхээр байна.

2.4.2. Захиргааны хэм хэмжээ тогтоосон актын талаар²⁶

ЦАХТТТ хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт энэ хуульд заасан хугацаанд төлөгдсөн байвал зохих шимтгэлтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу нийгмийн даатгалын санд шилжүүлэн төлнө гэж заасан.

Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу ЗГ-ын 1994 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн "Журам батлах тухай" 212 дугаар тогтоолоор "Нийгмийн даатгалын шимтгэл

²⁶ Хавсралт № 3 ЦАХТТТ хуульд заасан захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд

төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам” батлагдан улмаар ЗГ-ын 2008 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 26 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан байна.

ЦАХТТТ хуулийн 19 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1, 2, 3, 5, 6 дахь хэсэгт заасан тэтгэмж, дэмжлэг олгох журмыг **Засгийн газар тогтооно.**” гэж заасны дагуу ЗГ-ын 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн “Журам батлах тухай” 38 дугаар тогтоолоор “Цэргийн албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам” батлагдсан байна.

Улмаар ЗГ-ын 2011 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн “Журам батлах тухай” 9 дүгээр тогтоолоор дараах журмууд батлагджээ.

- “Цэргийн алба хаагчийн гэр бүлд тэтгэмж олгох журам”
- “Цэргийн алба хаагчид орон сууцны дэмжлэг үзүүлэх журам
- “Цэргийн тэтгэвэр авагчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүг нийгмийн даатгалын санд төлөх журам”

ЗГ-ын “2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 137 дугаар тогтоолоор ЗГ-ын 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн тэтгэвэр авагчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүг нийгмийн даатгалын санд төлөх журам”-д өөрчлөлт оруулсан байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн “Заавар батлах тухай” А/78 тоот тушаалын хавсралтаар “ЦАХТТТ хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, ЦАХТТТ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд баримтлах заавар” баталсан нь Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээ агуулсан актын шинжтэй байна.

ЦАХТТТ хуульд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргыг энэхүү заавар гаргах эрх зүйн үндсийг тусгаагүй байх бөгөөд судлахад дараах нөхцөл байдал дүгнэгдэж байна. Үүнд:

- Энэхүү зааврыг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, ЦАХТТТ хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2017 оны 3/828 дугаар албан бичгээр өгсөн, зөвлөмж, чиглэлийг үндэслэжээ.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг “Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана.”, Нийгмийн даатгалын хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг²⁷ нь нийгмийн даатгалын байгууллагын чиг үүргийг тодорхойлсон нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх” шаардлагыг хангаагүй байна.

- Энэхүү зааврын 1.2 дахь хэсэгт “Энэ заавраар зохицуулсан асуудал нь ЦАХТТТ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой урьд хүргүүлсэн журам, заавар, аргачлалаас

²⁷ Нийгмийн даатгалын хуулийн 24 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэг/

1. Нийгмийн даатгалын байгууллага дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

2/нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;

3/нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах;

4/улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

5/доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих;

6/хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

зөрүүтэй бол энэхүү зааврыг дагаж мөрдөнө” гэсэн нь захиргааны хэм хэмжээ тогтоосон гадагшаа чиглэсэн нийтээр дагаж мөрдөх шинжийг агуулсан байх бөгөөд агуулга нь хүчин төгөлдөр Засгийн газрын тогтоолоор баталсан захиргааны хэм хэмжээ тогтоосон акттай зөрчилдвөл зөвхөн энэ заавраа дагах үүргийг тогтоосон байна.

- Энэхүү зааврын 5.1.3 дахь хэсэгт “ ... тагнуул, шүүхийн шинжилгээ, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын цэргийн алба хаах насны дээд хязгаарыг Цэргийн албаны тухай хуульд зааснаар мөрдөнө.” гэж хуулийг зөрчин тайлбарлажээ.

Тухайлбал, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдана.”, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 нас байна.” заасныг зөрчсөн байна.

Мөн 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 289 дүгээр зүйлийн 289.1 дэх хэсэгт насны дээд хязгаарыг бага цолтой алба хаагч 47 нас, дунд цолтой алба хаагч 52 нас, ахлах цолтой алба хаагч 55 нас, дээд цолтой алба хаагч 57 нас гэж тогтоожээ.

- энэхүү журмын 6.1 дэх хэсэгт “Энэхүү заавар болон холбогдох хууль, тогтоомж зөрчсөн тохиолдолд үүсэх хариуцлагыг тухайн гэм буруутай албан тушаалтан хүлээнэ.” гэж Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6 дахь “хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх” заалтыг шаардлагыг зөрчсөн байна.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

1994 оны ЦАХТТТ хуулийн “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэхдээ аргачлалын дагуу хууль батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг шалган хууль бүхэлдээ зорилго, зорилтдоо нийцсэн эсэхийг үнэлэх юм.

Хууль батлагдах үеийн үзэл санаа, 2016 оны Цэргийн албаны тухай болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, 2018 оны Төрийн албаны тухай хуулиудын шинэчилсэн найруулгын үндсэн зорилгод суурилан ЦАХТТТ хуулийн нэршил, хууль зүйн техникийн хувьд харьцуулан 1 дүгээр зүйлийг үнэлгээний зүйлээр сонгон авч үзлээ.

3.1.1 Үнэлгээний зүйл 1

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч /энэ хуульд цаашид "цэргийн алба хаагч" гэх/ нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү хэсэгт нь 10 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.

Цэргийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар цэргийн албыг дор дурдснаар ойлгоно. Үүнд:

- Цэргийн жинхэнэ алба
- Цэргийн бэлтгэл алба

Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтаар “цэргийн алба” гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг ойлгоно” гэж тодорхойлжээ.

Эндээс ЦАХТТТ хуульд заасан 12 субъектээс зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэхийг цэргийн жинхэнэ хаах гэж дүгнэгдэж байна.

Харин ЦАХТТТ хуулийн үйлчлэлд байгаа цэргийн бэлтгэл албаны буюу дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн болон дор дурдсан алба, байгууллагын цэргийн бүртгэлтэй генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, эрх бүхий алба хаагч нь цэргийн бэлтгэл үүрэгтэн байна. Үүнд:

- цагдаагийн байгууллагын;
- шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын;
- тагнуулын байгууллагын;
- төрийн тусгай хамгаалалтын байгууллагын;
- авлигатай тэмцэх газрын;
- шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн;

ЦАХТТ хууль болон батлагдах болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн танилцуулгатай танилцахад УИХ-аас батлагдсан “Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын хүрээнд нийгмийн шаардлагын хүрээнд боловсруулагдан батлагдаж хууль үйлчлэн 26 жилийн хугацаанд нийгмийн харилцаагаа зохицуулж улам бүр боловсронгуй болсон байна.

Цаашид хууль сахиулах салбарын төрийн тусгай алба хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд ЦАХТТТ хуулийн зохицуулалтыг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуультай нэгтгэн шинэчлэх ч боломжтой байна.

3.2. Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд ЦАХТТТ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгүүдийн болон Төрийн албан хаагчийн буцалтгүй тусламж олгох эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоо, энэ зүйлүүд заасан “халагдах” гэсэн нэр томъёоны хууль зүйн техник, нэг удаагийн тэтгэмж бодох аргачлалыг сонгон авч үзлээ.

3.2.1. Үнэлгээний зүйл 2

8 дугаар зүйл. Цэргийн алба хаасны тэтгэвэр авах эрх

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг хангаагүй боловч 10-аас доошгүй жил цэргийн алба хаасан цэргийн алба хаагч дор дурдсан шалтгаанаар халагдсан бол цэргийн алба хаах насны хязгаарт хүрээд цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй:

- 1/ орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлтөөр;
- 2/ биеийн эрүүл мэндээр;
- 3/ цэргийн алба хаах нас хэтэрч.

18 дугаар зүйл. Нэг удаагийн тэтгэмж авах тохиолдол

1.Цэргийн алба хаагч нас барах, тэтгэвэрт гарах, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр болон цэргийн алба хаах нас хэтэрч халагдах тохиолдолд нэг удаагийн тэтгэмж олгоно.

19 дүгээр зүйл. Нэг удаагийн тэтгэмжийн хэмжээ

2.Цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдвал түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжээд 30 гаран жил өнгөрч байгаа боловч цэргийн тэтгэвэр тогтоолгоход олгодог тэтгэмж нь цэргийн алба хаагчийн нийгмийн хамгааллаа дээшлүүлэх үндсэн эх сурвалж болдог.

ЦАХТТТ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Цэргийн алба хаагч нас барах, тэтгэвэрт гарах, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр болон цэргийн алба хаах нас хэтэрч халагдах тохиолдолд нэг удаагийн тэтгэмж олгоно.”, 19

дүгээр зүйлийн 2 дахь хэсэг "Цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдвал түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно." гэж тус тус заасан байна.

Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна." гэж заасан.

Төрийн албаны тухай хуулийн төрийн алба хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгоод 36 сар хүртэл буцалтгүй тусламж авах ойлголт нь цэргийн алба хаагчийн нэг удаагийн тэтгэмж авах агуулгатай хууль зүйн учир холбогдол адил байна.

Гэвч ЦАХТТТ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тэтгэмж олгох харилцааг энэхүү хуулийн 8 дугаар зүйлд заасан ажилласан жилээр болон хувь тэнцүүлэн тэтгэвэрт гарах харилцаанаас уялдуулаагүй өргөжүүлэн орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр болон цэргийн алба хаах нас хэтэрч халагдах тохиолдолд 18 сарын нэг удаагийн тэтгэмж авахаар зохицуулсан эрх зүйн алдааг бий болгож алба хаагч, иргэдийн зүгээс ЦАХТТ хуулийг хэрэгжүүлдэггүй гэсэн асуудлыг бий болгосон байна.

Энэ нь сүүлийн үед улс төр, бусад шалтгаанаар цэргийн болон хууль сахиулах албанд томилогдон ажиллаж байгаад орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, эрүүл мэндээр чөлөөлөгдөх тохиолдолд ЦАХТТТ хуулийн дагуу 18 сарын тэтгэмж авах ёстой гэсэн хандлагыг бий болгож байсан ч дээрх тохиолдолд олгож байсан практик байхгүй байна.

Иймд ЦАХТТТ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эрх зүйн зохицуулалтыг тус хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр хувь тэнцүүлэн тэтгэвэр тогтоолгосонтой уялдуулан өөрчлөн найруулах шаардлагатай байгаа нь дүгнэгдлээ.

Түүнчлэн 1994 оны ЦАХТТТ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... халагдсан бол..." 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "... халагдах тохиолдолд", 19 дүгээр зүйлийн – дахь хэсэг "... халагдвал..." гэсэн нэр томъёог хуульчилж хэрэглэж иржээ.

Төрийн албаны тухай болон Цэргийн албаны хуульд чөлөөлөх, халах гэсэн нэр томъёог хууль зүйн техникийн хувьд хэрхэн хэрэглэснийг харьцуулалтаар дүгнэвэл:

	Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт	Цэргийн албаны тухай хууль 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг
Чөлөөлөх		
	1.Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших болсон; 2.тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн; 3.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн; 4.өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан; 5.хуульд заасан бусад үндэслэл.	1. анги, байгууллага татан буугдсан, орон тооны өөрчлөлтөөр албан тушаал нь хасагдсан; 2. өөр ажилд томилогдсон; 3. цэргийн жинхэнэ албанд биеийн эрүүл мэндээр тэнцэхгүй тухай цэргийн эмнэлгийн эмч нарын зөвлөгөөний дүгнэлт гарсан; 4. тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн; 5. алба хаах насны дээд хязгаарт хүрсэн; 6. өөрийн хүсэлтээр.
	Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт	Цэргийн албаны тухай хууль 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг
Халах		

Төрийн жинхэнэ албан хаагчийг дараах үндэслэлээр төрийн албанаас хална: 1.хуульд өөрөөр заагаагүй бол удаа дараа /3 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн; 2.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон; 3.Монгол Улсын харьяатаас гарсан; 4.энэ хуульд заасан бусад үндэслэл.	1. цэргийн нийтлэг дүрэм, цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг удаа дараа зөрчсөн; 2. гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон; 3. ЦАТ хуульд заасан мэргэжил, мэргэшил, ур чадварын түвшинд тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон.
--	---

Харин Цэргийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлд цэргийн албанаас хугацаат цэргийн алба хаагчийг бэлтгэлээр халах ойлголт тусгагдсан байна.

Иймд 1994 оны ЦАХТТТ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... халагдсан бол...” гэснийг “чөлөөлөгдсөн бол”, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... халагдах тохиолдолд ...” гэснийг “чөлөөлөгдсөн тохиолдолд”, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “... халагдвал...” гэснийг “чөлөөлөгдвөл” гэж тус тус хууль зүйн техникийн хувьд засах шаардлагатай байна.

Түүнчлэн ЗГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 7 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн алба хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно.” гэж журамласан нь төрийн алба хаагчийн буцалтгүй тусламжийн хэмжээ өндөр тогтоогдох боломжтой байна.

Харин ЗГ-ын 2011 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “38 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн алба хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам”-ын хавсралтын 3-т “ЦАХТТТ хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийг олгохдоо сүүлийн 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д хувааж гарсан дундаж цалин хөлсийг 36 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцно” гэж заасан нь амьдралд хэрэгжиж байгаа.

Иймд ЗГ-ын 2011 оны “38 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн алба хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам”-д нэмэлт оруулах замаар цалин хөлсний сүүлийн 3 жилийн дунджаар тооцвол эрх зүйн байдал дээрдэх хууль зүйн учир холбогдолтой байна.

3.2.2. Үнэлгээний зүйл 3

Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг

“... цэргийн алба хаагчийн тэтгэвэр авч байгаа энэ хуулийн 3.1-д заасан насанд хүрээгүй иргэн энэхуулийн 9 /Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ/, 11 дүгээр зүйл /Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих/-д заасан дэмжлэг, үйлчилгээнд хамрагдана.” гэж заажээ.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагч Б-тэй хийсэн ярилцлагаас: Би 25 жил ажиллаад “ажилласан жилээр” 2 жилийн өмнө цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоолгосон. ...Жил ирэх тусам улс орны эдийн засаг, мөнгөний үнэгүйдэлтэй холбоотой авч байгаа тэтгэврийн үнэ цэнэ буурч байна. Ихэнх цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагчид үргэлжлүүлэн ажиллах, ажил хайх шаардлага бий болдог. Бидний хувьд харуул хамгаалалтын ажилтан гэдэг ажил л олдох юм даа..... Дүүрэг, хорооны хөдөлмөр эрхлэлт, хувь хүний хөгжил, оролцоог дэмжих талаар арга хэмжээнд хамрагдаж үзээгүй ...

Ахмад насны тухай хууль²⁸-ийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн үйлчлэлд 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэн хамаарч Ахмад настны нийгмийн халамжийн тухай хуульд заасан халамж үйлчилгээнд хамрагддаг байна.

Харин цэргийн алба хаагч 20, 25 жил ажилласан хугацаагаар эсхүл эмэгтэй цэргийн алба хаагч 47 нас, эрэгтэй 47-57 насанд цэргийн албаны тэтгэвэрт гарах эрх зүйн харилцаа үүсэж, тэтгэвэрт гарсны дараа Ахмад настны нийгмийн халамжийн тухай хуулийн энэ хуулийн 9, 11 дүгээр зүйлд заасан дэмжлэг, үйлчилгээнээс бусад халамж үйлчилгээнд хуулийн дагуу болзолд заасан насанд хүрсэн тохиолдолд хамрагддаг байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагчдын тэтгэвэр, тэтгэмж нь улс орны нийгэм эдийн засгийн байдал ялангуяа мөнгөний инфляц, бүтээгдэхүүний үнийн өсөлт зэргээс шалтгаалан тодорхой цаг хугацааны дараа хүртээмжгүй болж амжиргааны түвшин буурч байгааг судалгаанд оролцогч тэтгэвэр авагчид дурдаж байсан.

Иймд цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагчийн эрүүл мэндийг хамгаалах, амьжиргааг дэмжих талаар Ахмад насны тухай хууль²⁹ ийн зохицуулалтад оруулах судалгааг явуулан хуульд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой гэж дүгнэж байна.

Тухайлбал, нийслэлээс 1000 километр ба түүнээс хол алслагдсан газарт байнга оршин суудаг цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагч аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлэгт дараалал харгалзахгүй үйлчилж, унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох, нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний тусламж олгох гэх мэт.

3.2.3. Үнэлгээний зүйл 4

ЦАХТТТ хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

“Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барахад түүний оршуулгад зориулан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж олгоно.”

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагч Н-тэй хийсэн ярилцлагаас:

Саяхан миний тэтгэвэр тогтоолгосон цэргийн найз бурхан болсон боловч Нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй гэдэг шалтгаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан оршуулгын тэтгэмж авах бололцоогүй юм билээ. Хуучин ажилласан байсан цэргийн байгууллагад дуулгаж тухайн үед хамт ажиллаж байсан хэд нь өөрсдийн боломжоороо тусалцаасан даа.

НДСОТТТ хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн **даатгуулагч** ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал түүний оршуулгад зориулан оршуулгын тэтгэмж олгоно.” гэж заасан байна.

ЦАХТТТ хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барахад түүний оршуулгад зориулан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж олгоно.” гэж заасан бөгөөд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн болон хөдөлмөр, нийгмийн зөвшлийн

²⁸ Ахмад настны тухай хууль Төрийн мэдээлэл № 13, 2017. Ахмад настны тухай хуульд зааснаар ахмад настны талаар төрөөс авах дараах арга хэмжээнүүд байдаг байна Үүнд:

- Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ
- Ахмад настны амьжиргааг дэмжих
- Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах
- Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих
- Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг

²⁹ Хавсралт № 4 Ахмад настны тухай хуулиас

3 талт үндэсний хорооны 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Оршуулгын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 16 дугаар тогтоолоор энэхүү оршуулгын тэтгэмжийг 1 сая төгрөгөөр тогтоожээ.

Цэргийн байгууллагын хүний нөөцийн ажилтантай хийсэн ярилцлагаас:

ЦАХТТТ хуульд цэргийн алба хаагч, дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барахад л түүний оршуулгад зориулан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж олгох эрх зүйн зохицуулалттай учраас цэргийн байгууллагаас тэтгэвэр авагч цэргийн үүрэгтэй нас барсан тохиолдолд туслах боломж хязгаарлагдмал бөгөөд гэр бүлийнхэнд нь учир байдлыг тайлбарлаад л өнгөрөхөд хэцүүтэй л байдаг. Ер нь хамт ажиллаж байсан одоо байгаа алба хаагчдаа хэл дуулгаад л цаашид хуульдаа тэтгэвэр авагч гээд нэмж оруулж болдоггүй юм байх даа л гэж боддог.

Ахмад настны тухай туулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтаар төрөөс “нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний тусламж олгох” дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалттай байх тул ЦАХТТТ хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч,” гэсний дараа “цэргийн тэтгэвэр авагч,” гэж хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар энэхүү асуудлыг шийдвэрлэх боломжтой байна.

Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон, Ахмад настны тухай хуульд заасан насны хязгаарт хүрээгүй байхдаа нас барсан цэргийн бэлтгэл үүрэгтний ар гэрт тэтгэмж олгогддог болно.

3.3 “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

ЦАХТТТ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “**дараалсан**” 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60 сард хуваан нэг удаагийн тэтгэмж олгох болон 17¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн цэргийн алба хаагч эмэгтэй хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаандаа дахин хүүхэд төрүүлсэн бол **уг эхийн зөвхөн хоёр удаагийн төрөлтөд** жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох эрх зүйн зохицуулалтыг “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийхээр тогтоосон болно.

3.3.1. Үнэлгээний зүйл 5

ЦАХТТТ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тэдний цэргийн алба хаасан сүүлийн 20 жилийн доторх **дараалсан** 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д, 5 хүртэл жил алба хаасан бол цэргийн алба хаасан нийт хугацаанд авсан цалин хөлсний нийлбэрийг алба хаасан сарын тоонд тус тус хувааж тодорхойлно.”

Цэргийн алба хаагч С-тэй хийсэн ярилцлагаас:

... Би 45 настай эмэгтэй, цэргийн алба хаагч бөгөөд жилийн 1 жилийн өмнө хүүхэд асрах чөлөө авсан. Хуулиар 47 нас хүрч тэтгэвэр тогтоолгох тохиолдолд хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацаанаас болж өмнөх дараалсан 5 жилийн цалин хөлсний дунджаар тэтгэвэр тогтоолгох тохиолдолд тэтгэвэр бага тогтоогдоно. Ийм ч шалтгаанаар өвчтэй хүүхдээ 3 жил асарч чадалгүй 1 жилийн дараа ажилдаа орсон... ажилд орсноос хойш 5 жил тасралтгүй ажиллах шаардлагатай боловч цаашид үргэлжлүүлэн миний насны дээд хязгаарыг сунгах болов уу гэж байнга сэтгэл эмзэглэж явна даа...

Түүнчлэн ЗГ-ын 2011 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “38 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн алба хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам”-ын хавсралтын 3 дахь хэсэгт “ЦАХТТТ хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийг

олгохдоо **сүүлийн 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д хувааж гарсан дундаж цалин хөлсийг 36 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцно**” гэж заасан нь байна.

Цэргийн алба хаагч Г-тэй хийсэн ярилцлагаас:

... Би ажиллаж байхдаа цэргийн сургуульд суралцсан юм. Одоо биеийн эрүүл мэндийн шалтгаанаар ажилласан жилээр тэтгэвэр тогтоолгох болсон ч сүүлийн дараалсан 5 жилд сургуульд сурсан хугацаа орж байгаа... сүүлийн 5 жилээр нэг удаагийн тэтгэмж маань буурна ...

Иймд ЦАХТТТ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “дараалсан” гэснийг гэснийг мөн 3Г-ын 2011 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “38 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн алба хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам”-ын хавсралтын 3-т заасан “сүүлийн” гэснийг өөрчлөлт оруулах замаар хүчингүй болгох нь алба хаасан хугацаа завсардсан цэргийн алба хаагч /сургууль сурсан, хүүхэд асрах чөлөө авсан, түр чөлөөлөгдсөн/ ялангуяа эмэгтэй алба хаагчид өөрийн сонгосон 5 жилийн дунджаар тооцуулах боломжтой болж эрх зүйн байдал дээшлэх хууль зүйн үр дагавартай байна.

3.3.2. Үнэлгээний зүйл 6

№	НДСОТТТ хууль	ЦАХТТТ хууль
1	19¹ дүгээр зүйл.Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх 3.Хөдөлмөр эрхэлж байгаад хууль тогтоомжид заасны дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд дахин хүүхэд төрүүлсэн эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно.	17¹ дүгээр зүйл. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх “Цэргийн алба хаагч эмэгтэй хууль тогтоомжид заасны дагуу хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаандаа дахин хүүхэд төрүүлсэн бол түүнд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно. Энэ тохиолдолд уг эхийн зөвхөн хоёр удаагийн төрөлт хамаарна. ”

2017 оны 02 сарын 02 өдрийн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйл “... хуулийн 19¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгээс “Энэ тохиолдолд уг эхийн чөлөөтэй байсан хугацааны хоёр удаагийн төрөлт хамаарагдана.” гэснийг ... хассугай.” гэж өөрчилсөн боловч ЦАХТТТ хуульд өнөөг болтол үйлчилсээр байна.

Улмаар хуулийн үйлчлэлд хамаардаг байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүд энэхүү хуулийн зохицуулалтыг хүний эрхийн үүднээс хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хүчингүй болгох эсхүл хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацаанд нэг, улмаар 2 дахь удаагийн тохиолдлын аль нь хамаарах талаар Улсын дээд шүүхийн тайлбар гаргуулах нь зүйтэй гэж дурдсаныг тэмдэглэх нь зүй.

Ингэснээр цэргийн эмэгтэй алба хаагчид дахин амаржиж хүүхэд төрүүлсэн бол жирэмсний тэтгэмж авах боломжтой болно.

3.3.3. Үнэлгээний зүйл 7

Нийгмийн даатгалын ерөнхий газрын НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын ахлах мэргэжилтэн С.Л-ын ярилцлагаас....³⁰ “... Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг³¹т “Тэтгэвэр авагч нь ажил хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд Эрүүл мэндийн болон Ажилгүйдлийн даатгалаас бусад даатгалыг албан журмаар төлнө” гэж заасан байдаг. ... Ингэхдээ тухайн тэтгэвэр авагч нь дээрх

³⁰ https://tovch.mn/n/16l7?fbclid=IwAR1RycUVsnyt-tapgZ9kp5-Le4cvjowDFyR1J_F0SOSD4DN-XY8_hclyTRU

³¹ Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна...”

даатгалуудыг 12 сараас дээш хугацаанд төлсөн бол хүсэлт гаргаж, авч буй тэтгэвэр дээрээ төлсөн шимтгэлийнхээ 1,5 хувийг нэмэгдүүлэх боломжтой” гэлээ.

Энэхүү ярилцлагад зарим иргэдийн бичсэнийг нарийвчилбал:

202.21.113.82 2021/03/29

3-4 сая төгрөгний шимтгэл төлөөд жилийн эцэст 18,000 төгрөг нэмдгээ тайлбарла даа 1,5% бусдыг нь төр

202.126.89.191 2021/03/30

Тэтгэврээ тогтоолгоод ажиллаж байхад яахаараа тэтгэврийн даатгал төлдөг юм бэ ... бид мөнхийн ус уусан хүмүүс биш шүү

27.123.213.66 2021/03/30

Бүтэн жил ажил хийж нийгмийн даатгалыг 760 мянган төгрөгнөөс төлөөд байхад 9500 төгрөг л нэмэгддэг энэ арай бишээ, энэ үеэ өнгөрөөсөн нийгмийн даатгалын тогтолцоог өөрчлөх цаг нь ирсэн шүү.

Цэргийн алба хаасны тэтгэвэр авагчдын тэтгэвэр тодорхой цаг хугацааны үнэ цэнэгүй болдог төдийгүй тэдгээрийн дийлэнх нь дахин иргэний байгууллагад ажил, хөдөлмөр эрхэлдэг байна.

Энэ ч утгаар эрүүл мэндийн болон ажилгүйдлийн даатгал төлдөггүй боловч бусад тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалыг нийт сар бүр 10,3 хувиар төлж улмаар 12 сар ажилласны дараа тэтгэврийг 1,5 хувиар нэмэгдүүлдэг байна. Харин хуульд зааснаар 4200000 төгрөгнөөс дээш цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол буцаан авах эрх зүйн зохицуулалттай байна.

Тухайлбал, 700000 төгрөгний тэтгэвэр авагч 1,2 төгрөгийн цалинтай ажил хийж зөвхөн өөрөө 2352000 төгрөгийн /ажил олгогчийнхийг оролцуулаагүй болно/ нийгмийн даатгалын шимтгэлийг төлж харин жилд 10500 төгрөгөөр тэтгэврээ нэмэгдүүлэхээр байгааг дээрх сэтгэгдэл бичсэн иргэд шүүмжилсэн байна.

3.3.4. Үнэлгээний зүйл 7

ЦАХТТТ хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

“Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч өөрөө хүсвэл цэргийн алба хаасан болон даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоож болно.”

Цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн ярилцлагаас:

... Би улсад 10 жил ажиллаад улмаар цэргийн байгууллагад 20 жил ажилласан бөгөөд улмаар цэргийн албаны тэтгэвэр тогтоолгоход энгийн байгууллагад ажилласаныг цэргийн шилжүүлэн 25 жил ажилласнаар цэргийн албаны тэтгэвэр тогтоолгосон боловч байгууллагаас нэг удаагийн тэтгэмж олгохдоо 18 сарын нэг удаагийн тэтгэмж авсан. ... Энгийнээ цэргийнх лүү шилжүүлж 25 жил тооцуулсан юм чинь 36 сарын тэтгэмж авах ёстой гэж хэлээд чадаагүй дээ.

Энэ нь авлига, тагнуул, цагдаа, төрийн тусгай хамгаалалт, шүүхийн шинжилгээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг байгууллагуудын алба хаагчдын хүний нөөцийн бүтэц, шилжилт, хөдөлгөөнтэй салшгүй холбоотой байдаг байна.

ЦАХТТТ хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан болзол хангасан цэргийн алба хаагчийн иргэний байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан нэг жилийг зургаан сараар бодон цэргийн байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцож ЦАХТТТ хуульд заасны дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоож болно.” гэж заасан.

ЦАХТТТ хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч эрэгтэй 25-аас доошгүй, эмэгтэй 20-оос доошгүй жил алба хаагаад цэргийн алба хаасны тэтгэвэрт гарахад түүнд 36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.” гэж заажээ.

Харин ЦАХТТТ хуулийн 6 дугаар зүйл 2 дахь хэсэгт зааснаар ЦАХТТТ хуульд заасан болзлыг хангаж тэтгэвэр тогтоолгохоор ажлаас чөлөөлөгдөсний дараа нийгмийн даатгалын байгууллагад энэхүү цэргийн алба хаасан болон даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр тогтоолгох агуулга тул нэгэнт хувь тэнцүүлж тэтгэвэрт гаргасан чөлөөлөх тушаалаар тэтгэмжийг 18 сараар олгож байна.

Харин ЦАХТТТ хуулийн 6 дугаар зүйл 2 дахь хэсэгт “цэргийн алба хаасны тэтгэвэр авагч” гэсний өмнө “цэргийн алба хаагч,” гэж нэмсэн тохиолдолд тэтгэвэр тогтоолгохоор тушаалаа гаргуулахаас өмнө өөрөө хүсвэл цэргийн алба хаасан болон даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцуулж бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх зүйн орчин бүрдэн улмаар нэг удаагийн тэтгэмжийг 36 сараар авах боломжтой талаар холбогдох байгууллагын хуулийн нэгж, алба хаагчид дурдаж байсныг тэмдэглэх зүйтэй байна.³²

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Цэргийн албаны онцлог, дүрэм, гүйцэтгэх үүргийн онцлогоос шалтгаалан цэргийн алба хаагчийн цэргийн албанд ажиллах насны дээд хязгаар, алба хаах нийт хугацаа болон шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоох харилцааг тусгайлсан хуулиар зохицуулдаг байна.

Сүүлийн жилүүдэд цэргийн албаны дээрх төрөлжсөн байгууллагад хамаарах цэргийн алба хаагчдад тэтгэвэр тогтоох, олгохтой холбоотой харилцааг зохицуулсан хууль эрх зүй нэлээдгүй шинэчлэгдэж өөрчлөгдсөн. Тухайлбал, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн албаны тухай, Монгол Улсын хилийн тухай хуулиуд 2016 онд, Цагдаагийн албаны тухай, Гамшгаас хамгаалах тухай, Дотоодын цэргийн тухай хуулиуд 2017 онд тус тус шинэчлэгдэн батлагджээ.

ЦАХТТТ хууль нь 1994 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлагдан 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйлчилснээс хойш энэхүү хуульд 23 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсныг дараах байдлаар дүгнэж байна Үүнд:

4.1. ЦАХТТТ хуулийг бүхэлд нь зорилгодоо нийцсэн эсэхийг авч үзвэл, УИХ-аас батлагдсан “Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын хүрээнд нийгмийн шаардлагын хүрээнд ЦАХТТ хууль болон батлагдах болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах хуулиуд боловсруулагдан батлагдаж хууль үйлчлэн 26 жилийн хугацаанд нийгмийн харилцаагаа зохицуулж улам бүр боловсронгуй болсон байна.

Цаашид Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтаар “цэргийн алба” гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг ойлгоно” гэж тодорхойлсон байх тул хууль сахиулах салбарын төрийн тусгай алба хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд ЦАХТТТ хуулийн зохицуулалтыг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуультай нэгтгэн шинэтгэх шаардлага гарахаар байна.

4.2. Цэргийн алба хаагч 20, 25 жил ажилласан хугацаагаар эсхүл эмэгтэй цэргийн алба хаагч 47 нас, эрэгтэй 47-57 насанд цэргийн албаны тэтгэвэрт гарах эрх зүйн харилцаа үүсэж, тэтгэвэрт гарсны дараа Ахмад настны нийгмийн халамжийн тухай хуулийн энэ хуулийн 9, 11 дүгээр зүйлд заасан дэмжлэг, үйлчилгээнээс бусад халамж үйлчилгээнд хуулийн дагуу болзолд заасан насанд хүрсэн тохиолдолд хамрагддаг байна.

Энэ нь цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагчдын тэтгэвэр, тэтгэмж нь улс орны нийгэм эдийн засгийн байдал ялангуяа мөнгөний инфляц, бүтээгдэхүүний үнийн өсөлт

³² ЦАХТТТ хуулийн 6 дугаар зүйл 2 дахь хэсэг “Цэргийн алба хаагч, цэргийн алба хаасны тэтгэвэр авагч өөрөө хүсвэл цэргийн алба хаасан болон даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоож болно.” гэж заасан.

зэргээс шалтгаалан тодорхой цаг хугацааны дараа хүртээмжгүй болж амьжиргааны түвшин буурч байгааг судалгаанд оролцогч тэтгэвэр авагчид дурдаж байна.

Өөрөөр хэлбэл 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй цэргийн хаагчийн тэтгэвэр авагч л Ахмад настны хуулийн үйлчлэлд хамаарч энэ насанд хүртэл төрийн нийгмийн халамж, үйлчилгээний гадна орхигдож байна.

4.3. Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон, Ахмад настны тухай хуульд заасан насны хязгаарт хүрээгүй байхдаа нас барсан цэргийн бэлтгэл үүрэгтний ар гэрт оршуулгын тэтгэмж олгогддоггүй байна.

Иймд Ахмад настны тухай туулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтаар төрөөс “нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний тусламж олгох” дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.4. Цэргийн ялангуяа цагдаа, шүүхийн шинжилгээний хүрээлэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн нь алба хаасан хугацаа тодорхой шалтгаанаар завсардсан /сургуульд сурсан, хүүхэд асрах чөлөө авсан, түр чөлөөлөгдсөн/ тохиолдолд тэдгээрийн цэргийн албаны тэтгэвэр, тэтгэмжээ буурч тогтоогддог нь ЦАХТТТ хуульд заасан дараалсан таван жил, холбогдох журамд заасан сүүлийн таван жил гэсэн тодотголтой холбоотой байна.

4.5. ЦАХТТТ хуулийн үйлчлэлд хамаарах төрийн тусгай албаны хууль тогтоомж³³-уудын өсгөн нэмэгдүүлэх эдийн засгийн баталгааг үндсэн 20, 25 жилээ гүйцээсний дараа олгохтой уялдуулсан эрх зүйн зохицуулалтыг хийгээгүйгээс төрийн зарим албад хүний нөөцийн эрсдэлт нөхцөл байдалд бий болгож иржээ. Жишээлбэл, Тулгар төрийн 2230, Их Монгол Улс байгуулагдсаны 815, Ардын хувьсгалын 100, Үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөгөө сэргээн мандуулсны 110 жилийн тохиох 2021 оны 07 дугаар сараас хойш олон төрийн тусгай хаагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгон тухайн байгууллагууд нэг удаагийн тэтгэмж олгох дараалал үүсэхээр байна.

4.6. ЦАХТТТ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тэтгэмж олгох харилцааг энэхүү хуулийн 8 дугаар зүйлд заасан ажилласан жилээр болон хувь тэнцүүлэн тэтгэвэрт гарах харилцаанаас уялдуулаагүй өргөжүүлэн орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр болон цэргийн алба хаах нас хэтэрч халагдах тохиолдолд 18 сарын нэг удаагийн тэтгэмж авахаар зохицуулсан эрх зүйн алдааг бий болгож алба хаагч, иргэдийн зүгээс ЦАХТТ хуулийг хэрэгжүүлдэггүй гэсэн асуудлыг бий болгосон дээрх тохиолдолд олгож байсан практик байхгүй байна.

4.7. 2017 оны 02 сарын 02 өдрийн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар НДСОТТТ хуулийн 19¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгээс “Энэ тохиолдолд уг эхийн чөлөөтэй байсан хугацааны хоёр удаагийн төрөлт хамаарагдана.” гэснийг хассан боловч ЦАХТТТ хуульд өнөөг болтол үйлчилсээр байна.

Улмаар хуулийн үйлчлэлд хамаардаг байгууллагуудын хүний нөөцийн мэргэжилтнүүд хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацаанд нэг, улмаар 2 удаагийн тохиолдлын аль нь хамаарах талаар Улсын дээд шүүхийн тайлбар гаргуулах эсэх талаар дурдаж байна.

4.8. Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Тэтгэвэр авагч нь ажил хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд эрүүл мэндийн болон ажилгүйдлийн даатгалаас бусад даатгалыг албан журмаар төлнө” гэж зааж тухайн тэтгэвэр авагч нь дээрх даатгалуудыг 12 сараас дээш хугацаанд төлсөн бол хүсэлт гаргаж, авч буй

³³ Хавсралт № 5 ЦАХТТТ хуульд заасан ажилласан хугацааг өсгөх эрх зүйн зохицуулалтууд

тэтгэвэр дээрээ төлсөн шимтгэлийнхээ 1,5 хувийг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтад ихээхэн шүүмжлэлтэй хандаж байна.

4.9. ЦАХТТТ хуулийн 6 дугаар зүйл 2 дахь хэсэгт зааснаар ЦАХТТТ хуульд заасан болзлыг хангаж тэтгэвэр тогтоолгохоор ажлаас чөлөөлөгдсөний дараа нийгмийн даатгалын байгууллагад энэхүү цэргийн алба хаасан болон даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр тогтоолгох агуулга тул нэгэнт хувь тэнцүүлж тэтгэвэрт гаргасан чөлөөлөх тушаалаар тэтгэмжийг 18 сараар олгож байна.

Харин ЦАХТТТ хуулийн 6 дугаар зүйл 2 дахь хэсэгт “цэргийн алба хаасны тэтгэвэр авагч” гэсний өмнө “цэргийн алба хаагч,” гэж нэмсэн тохиолдолд тэтгэвэр тогтоолгохоор тушаалаа гаргуулахаас өмнө өөрөө хүсвэл цэргийн алба хаасан болон даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцуулж бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх зүйн орчин бүрдэн улмаар нэг удаагийн тэтгэмжийг 36 сараар авах боломжтой талаар холбогдох байгууллагын хуулийн нэгж, алба хаагчид дурдаж байсныг тэмдэглэх зүйтэй байна.

4.10. Улсын дээд шүүхийн 32 дугаар тогтоолын тогтоолын 1. 2 дахь хэсэг нь Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсноор хүчин төгөлдөр байх шинж үгүйсгэгдэж харин 3 дахь “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-д заасан “цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй” гэдгийг тухайн албыг хаах насны дээд хязгаарт хүрснээс бусад тохиолдолд цэргийн албан хаагч өөрийн санаачилгаар тэтгэвэр тогтоолгох боломжтой гэж ойлгоно.” гэсэн хэсэг нь хүчинтэй гэж дүгнэгдэхээр байна.

4.11. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн “Заавар батлах тухай” А/78 тоот тушаалын хавсралтаар “ЦАХТТТ тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, ЦАХТТТ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд баримтлах заавар” баталсан нь Үндсэн хуульд заасан хуулийг гагцхүү Улсын дээд шүүх тайлбарлах агуулга, мөн Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.6 дахь заалт болон холбогдох хуулиудыг зөрчсөн гэж дүгнэгдэж байна.

ТАВ. САНАЛ:

Батлан хамгаалахын сайдын дэргэдэх байгуулагдах “Иргэний зөвлөл”-ийн үйл ажиллагаагаар Зэвсэгт хүчний үйл ажиллагаа нийгэмд илүү нээлттэй болж иргэний хяналтын тогтолцоо бүрдэх ялангуяа Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан цэргийн алба хаагчдын эрх зүйн байдал, нийгэм, эдийн засгийн баталгааны талаар холбогдох судалгааг хийн зохих өөрчлөлтийг хийнэ гэж дүгнэн дараах саналуудыг гаргаж байна.

5.1. 1994 оны ЦАХТТТ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... халагдсан бол...” гэснийг “чөлөөлөгдсөн бол”, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... халагдах тохиолдолд ...” гэснийг “чөлөөлөгдсөн тохиолдолд”, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “... халагдвал...” гэснийг “чөлөөлөгдвөл” гэж тус тус хууль зүйн техникийн хувьд засах

5.2. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, авагчийн эрүүл мэндийг хамгаалах, амьжиргааг дэмжих талаар Ахмад насны тухай хуулийн зохицуулалтад оруулах судалгааг явуулан хуульд нэмэлт өөрчлөлт оруулах

5.3. ЦАХТТТ хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч,” гэсний дараа “цэргийн тэтгэвэр авагч,” гэж хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагчийн оршуулгын тэтгэмжийг ар гэрт олгох асуудлыг шийдвэрлэх

5.4. ЦАХТТТ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “дараалсан” гэснийг гэснийг мөн ЗГ-ын 2011 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “38 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн алба хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам”-ын хавсралтын 3-т заасан “сүүлийн” гэснийг өөрчлөлт оруулах замаар хүчингүй болгох

5.5. ЦАХТТТ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эрх зүйн зохицуулалтыг тус хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр хувь тэнцүүлэн тэтгэвэр тогтоолгосонтой уялдуулан өөрчлөн найруулах

5.6. ЦАХТТТ хуулийн 17¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгээс “Энэ тохиолдолд уг эхийн зөвхөн хоёр удаагийн төрөлт хамаарна.” гэснийг хуульд өөрчлөлт оруулах замаар хүчингүй болгох

5.7. Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч өөрөө хүсвэл энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд даатгуулна...” гэж өөрчлөн найруулах

5.8. ЦАХТТТ хуулийн 6 дугаар зүйл 2 дахь хэсэгт “цэргийн алба хаасны тэтгэвэр авагч” гэсний өмнө “цэргийн алба хаагч, ” гэж нэмэх

5.9. ЗГ-ын 2019 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өлба хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын стандарттай ЗГ-ын 2011 оны “38 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн алба хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам”-ыг нийцүүлэн цэргийн алба хаагчийн цалин хөлсний сүүлийн 3 жилийн дунджаар нэг удаагийн тэтгэмжийг тооцох

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын хуулиуд

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль 1994.06.13 төрийн мэдээлэл №8
3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
4. Цэргийн албаны тухай хууль 2016.09. 01. Төрийн мэдээлэл № 36. 2016
5. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль 2016.09. 01, Төрийн мэдээлэл № 36. 2016
6. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хууль 1994.06.07, Төрийн мэдээлэл №. 1994
7. Төрийн албаны тухай хууль
8. Ахмад настны хууль
9. Гамшгаас хамгаалах тухай хууль
10. Цагдаагийн албаны тухай хууль
11. Дотоодын цэргийн тухай хууль
12. Дотоодын цэргийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
13. Монгол Улсын хилийн тухай хууль
14. Монгол Улсын хилийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
15. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
16. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль батлагдсантай холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай” 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 60 дугаар тогтоол

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1. “Журам батлах тухай” 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 7 дугаар тогтоол
ХАВСРАЛТ: Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам
2. “Журам батлах тухай” 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 11 дүгээр тогтоол
ХАВСРАЛТ: “Цэргийн гэрээт алба хаах журам”
3. “Тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тухай” 2008 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 26 дугаар тогтоол
4. “Журам батлах тухай” 2011 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 9 дүгээр тогтоол
ХАВСРАЛТ-1: “Цэргийн алба хаагчийн гэр бүлд тэтгэмж олгох журам”
ХАВСРАЛТ-2: “Цэргийн алба хаагчид орон сууцны дэмжлэг үзүүлэх журам”
ХАВСРАЛТ-3: “Цэргийн тэтгэвэр авагчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүг нийгмийн даатгалын санд төлөх журам”
5. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 137 дугаар тогтоол
6. “Журам батлах тухай” 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 38 дугаар тогтоол
ХАВСРАЛТ: “Цэргийн албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам”
7. “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт батлах тухай 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 281 дүгээр тогтоол

8. “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээ болон цалингийн итгэлцүүрийг шинэчлэн тогтоох тухай” 2014 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 15 дугаар тогтоол
ХАВСРАЛТ: “Шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр”
9. “Журам батлах тухай” 1994 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 212 дугаар тогтоол
ХАВСРАЛТ: “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”
10. “Дүрэм шинэчлэн батлах тухай” 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 269 дүгээр тогтоол
ХАВСРАЛТ: “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”
“Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт
“Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”
“Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн 2 дугаар хавсралт-“Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай яаралтай мэдэгдэх хуудас
11. “Дүрэм шинэчлэн батлах тухай” 2015 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоол ХАВСРАЛТ: “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”
12. “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2020 оны хэмжээг тогтоох тухай” 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 477 дугаар тогтоол

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
БОЛОН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ЗӨВШИЛИЙН 3 ТАЛТ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ**

1. “Оршуулгын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 16 дугаар тогтоол
2. Хөдөлмөр, нийгмийн зөвшилийн 3 талт үндэсний хорооны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2018 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 5 дугаар тогтоол

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖТЭЙ
ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН
БУСАД ТОГТООЛ, ШИЙДВЭРҮҮД**

1. “Заавар шинэчлэн батлах тухай” Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А85/241 тоот хамтарсан тушаал
ХАВСРАЛТ: “Иргэн (даатгуулагчийн) хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх заавар”
2. “Даатгуулагч (иргэн)-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/39, А/12 дугаар хамтарсан тушаал
ХАВСРАЛТ-1: “Даатгуулагч (иргэн)-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт, хувь хэмжээ, хугацаа
ХАВСРАЛТ-2: “Даатгуулагч (иргэн)-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт, хувь хэмжээ, хугацаа
3. “Журам шинэчлэн батлах тухай” Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн А/30 дугаар тушаал

4. “Заавар батлах тухай” Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн А/78 тоот тушаал

ХАВСРАЛТ: “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд баримтлах заавар”

5. “Дотоодын цэргийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь заалтад хамаарах албан тушаал”

Гарын авлага, нэг сэдэвт бүтээл

1. Чилхаажавын Дагвадорж “Нийгмийн хамгаалал” онол-арга зүй, туршлага, харьцуулалт, 2004, УБ.178 дугаар тал
2. Басангийн Батжаргал “Нийгмийн даатгал” нийгмийн даатгалын байцаагч, ажилтан, ажил олгогч, даатгуулагч, бичил уурхайчдад зориулсан сурах бичиг, гарын авлага, 2018, УБ115-129 дэх дахь талууд
3. Басангийн Батжаргал “Нийгмийн даатгал” нийгмийн даатгалын байцаагч, ажилтан, ажил олгогч, даатгуулагч, бичил уурхайчдад зориулсан сурах бичиг, гарын авлага /Нэмж засварласан хоёр дахь хэвлэл/, 2019, УБ121-136 дахь талууд
4. Басангийн Батжаргал “Нийгмийн даатгал-тэтгэвэр тэтгэмж бодох арга зүй” ажил, олгогч, даатгуулагч нийгмийн даатгалын байцаагч, ажилтан, суралцагчдад зориулсан гарын авлага /Нэмж засварласан хоёр дахь хэвлэл/, 2019, УБ108-127 дахь талууд
5. Хамтын бүтээл " Нийгмийн хамгааллын эрх зүй" гарын авлага. 2013, УБ 74-82 угаар талууд
6. Нийгмийн даатгалын ерөнхий газар “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийн тухай” танилцуулга 2016, УБ
7. Содномзундуйн Эрдэнэ “Нийгмийн даатгалын тогтолцоо: хөгжил, чиг хандлага” 2013, УБ
8. Хууль зүйн үндэсний хүрээлэн “Нийгмийн даатгалын эрх зүйн баримт бичиг” асуулт хариулт 2020, УБ. 31-36 дахь тал

Цахим эх сурвалж

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://www.legalinfo.mn/advanced-search>
- https://tovch.mn/n/1617?fbclid=IwAR1RycUVsnyt-tapgZ9kp5Le4cvjowDFyR1J_F0SOSD4DN-XY8_hclyTRU
- <http://www.parliament.mn/files/125798>
- [NOM_2003.p65 \(dcaf.ch\)](#)
- [Потапова-Н.Д.-Уч.пособие-Пенсионное-обеспечение-военнослужащих-в-РФ.pdf](#)
- [RL34751.pdf](#)
- [Defence-lbehera-vinay-280220_com_n.pdf](#)

НДСОТТТ ХУУЛЬ, ЦАХТТТ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ ХЭСГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

№	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хууль	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
1	4 дүгээр зүйл. Өндөр насны тэтгэвэр авах эрх 1.Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 65 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно. 2.Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, 50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. 3.Газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажилласан даатгуулагч дор дурдсан болзлыг хангасан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй: 1/нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь газрын дор ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр; 2/нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 50 нас хүрсэн, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаагаар мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 45 нас хүрсэн бол тус тус өөрийн хүсэлтээр. 3/нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй хугацаагаар хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь мөн нөхцөлд ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол тус тус өөрийн хүсэлтээр. 6.Сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол дуучин, бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийчин, найрал хөгжмийн үлээвэр хөгжимчнөөр	8 дугаар зүйл. Цэргийн алба хаасны тэтгэвэр авах эрх 1.Цэргийн алба хаагч нь дор дурдсан үндэслэлээр нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй: 1/ 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй; 2/ 20-оос доошгүй жил алба хаасан эмэгтэй; 3/ байлдааны нисдэг тэрэгний нисгэгчээр 23-аас доошгүй жил цэргийн алба хаасан; 4/ байлдааны тийрэлтэт сөнөөгч онгоцны жинхэнэ нисгэгчээр 20-оос доошгүй жил цэргийн алба хаасан. 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг хангаагүй боловч 10-аас доошгүй жил цэргийн алба хаасан цэргийн алба хаагч дор дурдсан шалтгаанаар халагдсан бол цэргийн алба хаах насны хязгаарт хүрээд цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй: 1/ орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлтөөр; 2/ биеийн эрүүл мэндээр; 3/ цэргийн алба хаах нас хэтэрч. 3.Цэргийн алба хаах насны хязгаарыг энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1

20-оос доошгүй жил ажилласан, эсхүл нийтдээ 25-аас доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил дурдсан мэргэжлээр ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн иргэн, мөн 25-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажилласан даатгуулагч, мөн 25-аас доошгүй жил Монгол Улсын шүүхийн шүүгчээр ажилласан шүүгч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн шүүгч өндөр насны тэтгэвэр тогтоолгоно. 7.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан иргэн доор дурдсан болзол хангасан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй: 1/нийт 20-иос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн бол; 2/нийт 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол.	дэх хэсгийн 1-д заасан байгууллагын эрх зүйн байдлыг зохицуулсан хуулиар, тусгайлан зохицуулаагүй бол Цэргийн албаны тухай хуульд заасныг мөрдөнө.
--	---

**ЦАХТТТ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ТЭТГЭВЭР АВАГЧДЫН
ТОО, ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ³⁴**

он	Тэтгэврийн төрөл							
	Цэргийн алба хаасны		Хөдөлмөрийн чадвар алдсаны		Тэжээгчээ алдсаны		нийт	
	хүн	хөрөнгө	хүн	хөрөнгө	хүн	хөрөнгө	хүн	хөрөнгө
1995	243	12.7	67	2.6	90	4.0	400	19.3
1996	707	66.4	130	8.4	197	14.0	1034	88.8
1997	7271	961.7	355	39.6	570	68.1	8196	1069.4
1998	6119	1.661.3	1715	67.0	734	122.2	8568	1850.5
1999	6363	1.851.7	1760	67.2	828	136.2	8951	2.055.1
2000	8015	3.233.5	419	109.9	923	221.8	9357	3.565.2
2001	8131	3.411.5	424	111.6	1007	265.4	9562	3.788.5
2002	9136	3.804	446	137	1047	306	10629	4.246.3
2003	9716	4.798.8	481	164	1076	372.4	11273	5.335.2
2004	10294	5.870	502	221.7	1101	491.8	11897	6.583.5
2005	10980	7.107.2	520	251.5	1172	518.8	12672	7.877.5
2006	11280	9.500.7	503	293.1	1106	633.9	12889	10.427.7
2007	11676	14.584.1	503	411.1	1088	883	13267	15.878.2
2008	11977	19.990.4	507	561.3	1021	1.146.2	13505	21.697.9
2009	12386	20.635.1	491	542.6	952	1.064.6	13829	22.242.3
2010	12598	22.755.2	542	586.5	917	1.056.7	14057	24.398.4
2011	12810	28.590.9	563	777.9	904	1.264.1	14277	30.632.9
2012	13372	58.532.5	587	1.264.1	938	1.966.1	14897	61.762.6
2013	13991	68.880.6	611	1.478.1	989	2.279.0	15591	72.637.7
2014	14551	75.967.7	571	1.673.7	966	2.610.6	16088	80.252.0
2015	14678	86.632.6	541	1.697.0	956	2.900.5	16175	91.230.1
2016	15266	93.090.1	493	1.682.2	949	3.068.1	16708	97.840.3

³⁴ Хөдөлмөр нийгмийн яам, Эрүүл мэнд нийгмийн даатгалын газар “Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл” 2017, УБ.53-55 талууд, 64-67 дахь талууд

№	ЦАХТТТ хуулийн 22 дугаар зүйл. Цэргийн алба хаасан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцох
1	1.Генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагчаар 10-аас доош жил алба хаасан бол уг хугацааг тухайн иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно. 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаагаар цэргийн алба хаасан иргэн өндөр насны болон тахир дутуугийн тэтгэвэр, эсхүл тухайн иргэн нас барсан бол түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргасан тохиолдолд уг хугацаанд төлөгдсөн байвал зохих шимтгэлтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу нийгмийн даатгалын санд шилжүүлэн төлнө. Захиргааны хэм хэмжээ тогтоосон акт ЗГ-ын 1994 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Журам батлах тухай” 212 дугаар тогтоолын хавсралтаар “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам” батлагдсан байна. ЗГ-ын 2008 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 26 дугаар тогтоолоор ЗГ-ын 212 дугаар тогтоолд өөрчлөлт оруулсан байна.
2	19 дүгээр зүйл. Нэг удаагийн тэтгэмжийн хэмжээ 1.Цэргийн алба хаагч эрэгтэй 25-аас доошгүй, эмэгтэй 20-оос доошгүй жил алба хаагаад цэргийн алба хаасны тэтгэвэрт гарахад түүнд 36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно. 2.Цэргийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч халагдвал түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно. 3.Цэргийн алба хаагчийн нэг удаагийн тэтгэмжийн 18 сар хүртэлх хугацаанд ногдох хэсгийг цэргийн алба хаасны тэтгэвэр авах эрх үүссэнээс хойш үргэлжлүүлэн алба хааж байгаа офицер, ахлагчид өөрийн нь хүссэнээр цэргийн албанаас чөлөөлөгдөхөөс өмнө урьдчилан олгож болно. 5.Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах цэргийн анги, байгууллагад ажиллаж байгаа энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-5 дахь заалтад заасан албан хаагчийн гэр бүлийн гишүүн /эхнэр, нөхөр/-ий аль нэг нь 3 сараас доошгүй хугацаагаар ажил эрхлээгүй байгаа бол Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг улиралд нэг удаа олгоно. 6.Цэргийн байгууллагад тасралтгүй 25-аас доошгүй жил ажилласан цэргийн алба хаагчид орон сууцны дэмжлэг үзүүлнэ. 7.Энэ зүйлийн 1, 2, 3, 5, 6 дахь хэсэгт заасан тэтгэмж, дэмжлэг олгох журмыг Засгийн газар тогтооно. Захиргааны хэм хэмжээ тогтоосон акт ЗГ-ын 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн “Журам батлах тухай” 38 дугаар тогтоол ХАВСРАЛТ: “Цэргийн албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам” ЗГ-ын 2011 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн “Журам батлах тухай” 9 дүгээр тогтоол ХАВСРАЛТ-1: “Цэргийн алба хаагчийн гэр бүлд тэтгэмж олгох журам” ХАВСРАЛТ-2: “Цэргийн алба хаагчид орон сууцны дэмжлэг үзүүлэх журам ХАВСРАЛТ-3: “Цэргийн тэтгэвэр авагчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүг нийгмийн даатгалын санд төлөх журам” “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 137 дугаар тогтоол

АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИАС

Ахмад насны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг “Энэ хуулийн үйлчлэлд 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэн хамаарна.”, **3.2** дахь “Нийгмийн даатгалын сангаас өндөр насны, эсхүл цэргийн алба хаагчийн тэтгэвэр авч байгаа энэ хуулийн 3.1-д заасан насанд хүрээгүй иргэн энэ хуулийн 9, 11 дүгээр зүйлд заасан дэмжлэг, үйлчилгээнд хамрагдана.” гэж заажээ.

9 дүгээр зүйл. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

9.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаа болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

9.1.1. хөдөлмөр эрхлэх хүсэлтэй ахмад настныг бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлэх;

9.1.2. энэ хуулийн 9.1.1-д заасан мэдээллийн санд бүртгэгдсэн ахмад настныг ажилд зуучлах, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэхийг дэмжих, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх, жижиг зээл олгох, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах;

9.1.3. ахмад настан нь залуу үед амьдрах ухаан, аж ахуй эрхлэх болон бусад чиглэлээр танхимын, зайны, шавь сургалт явуулахыг дэмжиж ажиллах.

9.2. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг жил бүр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл баталж, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтан хэрэгжүүлнэ.

9.3. Төрийн захиргааны төв байгууллага өөрийн салбарт зөвлөх мэргэжилтнээр ажиллах мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ахмад настны бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, тэднийг төрийн бодлого, хууль тогтоомж боловсруулах, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх ажилд оролцуулах арга хэмжээ авна.

9.4. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үндэсний хэмжээнд ажиллах мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ахмад настны бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, тэднийг мэргэжлийн чиглэлээр нь сургагч багшаар бэлтгэх, зөвлөх үйлчилгээнд зуучлах ажлыг зохион байгуулна.

9.5. Ахмад настны санаачилгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд нийт ажиллагсдын 50-аас доошгүй хувийг нь ахмад настан эзэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, хоршоонд Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр хөрөнгө, зээл олгож дэмжлэг үзүүлж болно.

9.6. Аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагатай ахмад настныг үргэлжлүүлэн ажиллуулж болно.

9.7. Энэ хуулийн 9.1.1, 9.3, 9.4-т заасан мэдээллийн санг удирдах, ашиглах журмыг Засгийн газар батална.

9.8. Аж ахуйн нэгж, байгууллага нь ахмад настныг тухайн байгууллагын зорилго, зорилт, хууль ёсны эрх ашигт нийцсэн сайн дурын ажил хийхийг дэмжиж болох бөгөөд сайн дурын ажил хийх ахмад настныг ажиллах нөхцөлөөр хангана.

11 дүгээр зүйл. Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих

11.1.Ахмад настны хөгжил, оролцоог төрөөс дараахь байдлаар дэмжинэ:

11.1.1.өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настныг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх хөтөлбөрийг Засгийн газар баталж, хэрэгжүүлэх;

11.1.2.нутгийн захиргааны байгууллага нь ахмад настанд биеийн тамир, спорт, соёл, урлагийн барилга, байгууламж, талбайг үнэ төлбөргүй ашиглуулах, ахмад настны дунд биеийн тамир, спорт, урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулах, ахмадын баг, хамтлаг, клубыг үйл ажиллагаа явуулах байраар үнэ төлбөргүй хангах үүрэг хүлээх;

11.1.3.нутгийн захиргааны байгууллага нь ахмад настанд зориулан чөлөөт цагийн танхим, мэдээллийн төвийг ажиллуулан ахмад настанд сэтгэл зүйн болон бусад зөвлөгөө өгөх.

10 дугаар зүйл. Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах

10.1.Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр төрөөс дараахь дэмжлэгийг үзүүлнэ:

10.1.1.сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв нь ахмад настанд зориулж насжилтаас үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, сургалтыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулах;

10.1.2.эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг, хүндэт донор ахмад настанд 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

10.1.3.нийслэлээс 1000 километр ба түүнээс хол алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлэг тухайн ахмад настанд дараалал харгалзахгүй үйлчилж, унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;

10.1.4.сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв нь хэвтрийн болон архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй ахмад настныг байнгын хяналтад авч, асран сувилах тусламж үзүүлэх явуулын үйлчилгээг ахмад эмч болон сувилагч, тусгайлан бэлтгэсэн сайн дурын ажилтныг оролцуулан зохион байгуулах;

10.1.5.гэрээр асруулж байгаа байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй ахмад настанд Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.6-д заасан мөнгөн тусламж олгох;

10.1.6.ахмад настны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ахмад настны кабинет, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвд ахмад настны эмч, эсхүл ахмад настны эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил, ур чадвар эзэмшсэн эмч ажиллуулах.

10.2.Ахмад настанд хөнгөлөлттэй үнээр эм олгох бөгөөд хөнгөлөлттэй үнээр олгох эмийн нэр төрөл, хөнгөлөлтийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

8 дугаар зүйл.Ахмад настны амьжиргааг дэмжих

8.1.Ахмад настны амьжиргааг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулахад төрөөс дараахь дэмжлэгийг үзүүлнэ:

8.1.1.хөл, гарны протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг таван жилд нэг удаа, шүд /үнэт металлаар хийхээс бусад/-ний протезийн дотоодод хийлгэсэн зардлын үнийг гурван жилд нэг удаа тус тус нийгмийн халамжийн, эсхүл эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн олгох;

8.1.2.ахмад настанд амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр олгох;

8.1.3.тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настан, хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

8.1.4.нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний тусламж олгох;

8.1.5.ахмад настан нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчих бөгөөд нийтийн тээврийн байгууллага ахмад настныг нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;

8.1.6.ахмад настанд олгох нийтийн тээврийн хэрэгслийн төлбөрийг харьяа аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх.

8.2.Энэ хуулийн 8.1.2-т заасан амралт, сувиллын газрын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, энэ хуулийн 8.1.5-д заасан нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журмыг Засгийн газар батална.

8.3.Ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцийн өөрчлөлтийг харгалзан Засгийн газар тухай бүр нэмэгдүүлнэ.

**ЦАХТТТ ХУУЛЬД ЗААСАН АЖИЛЛАСАН ХУГАЦААГ
ӨСГӨХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД**

№	Хуулийн нэр	огноо	Хугацааг өсгөн тооцох хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт
1	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль	2016 09.01	7.1.3.тайван цагт энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагч, нисэх цагийн нормоо биелүүлсэн байлдааны сөнөөгч онгоц, байлдааны нисдэг тэрэгний нисэх бүрэлдэхүүн, хилийн отряд, застав болон тэдгээртэй адил нөхцөлд байрлаж байгаа цэргийн анги, байгууллага, салбарын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцох;
2	Дотоодын цэргийн тухай хууль	2017 02.09	36.3.Дотоодын цэргийн алба хаагчийн ажилласан хугацааг тооцоход улсын онц чухал объектын харуул хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцно.
3	Гамшгаас хамгаалах тухай хууль	2017 02.02	50.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно
4	Цагдаагийн албаны тухай хууль	2017 02.09	86.2.Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно.
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	2017 06.09	286.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн баривчлах байр, цагдан хорих төв, цагдан хорих байр, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хаалттай хорих ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сар, нээлттэй хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага болон харьяа бусад байгууллагад 1 жил ажилласан хугацааг 1 жил 2 сар ажилласанд тооцно.
6	Тагнуулын байгууллагын тухай хууль	1999 07.08	25.7.Гадаадын тусгай алба, байгууллага, гэмт бүлэглэлд нэвтрэн тусгай үүрэг гүйцэтгэсэн, ажиглалтын албанд болон техникийн албаны тусгай нэгжид ажилласан нэг жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно.
7	Шүүхийн шинжилгээний тухай хууль	2009. 12.03	43.2.Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно.
8	Дипломат албаны тухай хууль	2000 10.05	22.4. Дипломат төлөөлөгчийн газарт ажилласан хугацааг тухайн ажиллагчдын төрийн алба хаасан нийт хугацаанд, цэргийн алба хаагчийн хувьд цэргийн жинхэнэ алба хаасан хугацаанд оруулж тооцох бөгөөд цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад алба хаасан нэг жилийг 1 жил 6 сараар тооцно.
9		1995	16 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа

	Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль	04.27	11.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон барилга, бусад зүйлийн гадна цэгт болон далд хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно.
--	--	-------	--

**ЦАХТТТ ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭЛД ХАМРАГДАХ ТӨРИЙН
ТУСГАЙ АЛБА ХААГЧДЫН АЖИЛЛАХ НАСНЫ ДЭЭД ХЯЗГААР**

№	Хуулийн нэр	Ажиллах насны дээд хязгаар заасан зүйл хэсэг, заалтууд
1	Цэргийн албаны тухай хууль	10.5.Иргэн ахлагчийн албыг 47 нас хүртэл хаана. 10.6.Алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар, дадлагатай ахлагчийн цэргийн жинхэнэ алба хаах хугацааг томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно. 11.4.Офицерын албыг дунд офицер 47 нас хүртэл, ахлах офицер 52 нас хүртэл, дээд офицер 57 нас хүртэл хаана. 11.5.Эмэгтэйчүүд офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл хаана. 11.6.Алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар, дадлагатай офицерын цэргийн жинхэнэ алба хаах хугацааг томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно. 11.7.Ажлын зайлшгүй шаардлага, мэргэжлийн онцлогийг харгалзан цэргийн сургуулийн багш, цэргийн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн офицерын алба хаах хугацааг дахин сунгаж болно.
2	Цагдаагийн албаны тухай хууль	91.1.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан үндэслэлээр цагдаагийн алба хаагч тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авах эрхтэй бөгөөд алба хаах насны дээд хязгаар нь: 91.1.1.цагдаагийн бага цолтой алба хаагч 47 нас; 91.1.2.цагдаагийн дунд цолтой алба хаагч 52 нас; 91.1.3.цагдаагийн ахлах цолтой алба хаагч 55 нас; 91.1.4.цагдаагийн дээд цолтой алба хаагч 57 нас; 91.1.5.цагдаагийн бага цолтойгоос бусад эмэгтэй алба хаагчийн алба хаах насны дээд хязгаар нь 47 нас байна. 91.2.Энэ хуулийн 91.1-д заасан насны дээд хязгаарт хүрсэн цагдаагийн алба хаагчийн алба хаах хугацааг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 хүртэл жилээр сунгаж болно. 91.3.Цагдаагийн алба хаагч энэ хуулийн 91.1-д заасан насны дээд хязгаарт хүрмэгц албанаас чөлөөлөгдөх, дахин 1 жилээр сунгуулах тухай хүсэлтээ насны дээд хязгаарт хүрэх хугацаа болохоос 3 сарын өмнө гаргаагүй нь захиргааны санаачилгаар түүнийг албанаас чөлөөлөхөд саад болохгүй.
3	Төрийн албаны тухай хууль	41 дүгээр зүйл.Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаа 41.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 нас байна.

4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	289.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авах эрхтэй бөгөөд алба хаах насны дээд хязгаар нь: 289.1.1.бага цолтой алба хаагч 47 нас; 289.1.2.дунд цолтой алба хаагч 52 нас; 289.1.3.ахлах цолтой алба хаагч 55 нас; 289.1.4.дээд цолтой алба хаагч 57 нас; 289.1.5.бага цолтойгоос бусад эмэгтэй алба хаагчийн алба хаах насны дээд хязгаар нь 47 нас байна. 289.2.Энэ хуулийн 289.1-д заасан насны дээд хязгаарт хүрсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн алба хаах хугацааг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 хүртэл жилээр сунгаж болно. 289.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч энэ хуулийн 289.1-д заасан насны дээд хязгаарт хүрмэгц албанаас чөлөөлөгдөх, дахин нэг жилээр сунгуулах тухай хүсэлтээ насны дээд хязгаарт хүрэх хугацаа болохоос 3 сарын өмнө гаргаагүй нь захиргааны санаачилгаар түүнийг албанаас чөлөөлөхөд саад болохгүй.
---	---------------------------------------	---